



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ139-14

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

### Аэродромын Гэрчилгээжүүлэлт - Аэродромын Онцгой Байдлын Журам

2016 оны 4 сарын 27

#### Ерөнхий зүйл

Иргэний нисэхийн ерөнхий газрын зөвлөмжийн цувралууд нь холбогдох дүрмийн шаардлагуудад нийцсэн эсэх нь ИНЕГ-ын Даргаар зөвшөөрөгдсөн стандарт, аргачлал болон журмын талаарх мэдээллүүдийг агуулсан байна.

Дүрмийн шаардлагадуудад нийцсэн гэдэг нь зөвхөн холбогдох дүрмийн шаардлагатай холбож ойлгож болохгүй бөгөөд дүрмийн шаардлагыг биелүүлж болох өөр арга хэрэгслүүд ИНЕГ-ын Даргад танилцуулагдах боломжтой. Шаардлагатай тохиолдолд энэ зөвлөмжийн цувралд хамаарах шинэ стандарт, үйл ажиллагаа, журам нэмэгдэн орж болно.

Түүнчлэн энэ зөвлөмжийн цуврал нь дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий гарын авлага болох материалыг агуулдаг бөгөөд гарын авлага нь заавал дагаж мөрдөх албагүй юм.

#### Зорилго

Энэхүү Зөвлөмжийн цуврал нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдэд Онцгой байдлын журмыг төлөвлөхөд туслах зорилготой ИНД-139, Аэродромыг гэрчилгээжүүлэлт ба үйл ажиллагаа-ны шаардлагад нийцсэн баримт бичиг юм. Энэхүү баримт нь аэродромын дараах төрлийн гэрчилгээ хүсэгчдэд болон эзэмшигчдэд зориулагдсан. Үүнд:

- Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ
- Шаардлага хангасан Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ

Энэ нь бас аэродромын гэрчилгээ эзэмшдэггүй үйл ажиллагаа эрхлэгчдэд мөн зориулагдсан болно.

#### Хамаарах дүрэм

Энэхүү Зөвлөмжийн цуврал нь ИНД 139-ийн шаардлагад хамаарах бөгөөд ялангуяа 139.57 Аэродромын Онцгой байдлын журам, ИНД 139.109 Онцгой байдлын журамтэй байх, ИНД 139.23 шаардлага хангасан аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн шаардлагууд зэрэг орно.

#### Өөрчлөлтийн бүртгэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн

байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-139-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

ЗЦ139-14-ийг NZ АС139-14-ийн 2015 оны 10 сарын 30-ны өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>1. ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>6</b>
1.1 Зорилго.....	6
<b>2. АЭРОДРОМЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ЖУРАМ.....</b>	<b>8</b>
2.1 Танилцуулга .....	8
2.2 Аэродромын Онцгой байдлын журмын шаардлагад.....	8
2.3 Аэродромын Онцгой байдлын журмын агуулга.....	8
2.3.1 Онцгой байдлын төрлүүд .....	8
2.3.2 Онцгой байдлын үед яаралтай авах арга хэмжээний журам .....	9
2.3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал .....	9
2.3.4 Байгууллагуудын үүрэг хариуцлага болон хийх ажлууд .....	9
2.3.5 ОБ-г зохицуулах төв болон Удирдлагын штабын үүрэг.....	10
2.3.6 Эмнэлгийн болон бусад боломжит тоног төхөөрөмж, техникүүдийн байршил болон тодорхойлолт .....	10
2.3.7 Онцгой байдалд оролцогч байгууллагуудын холбоо барих мэдээлэл .	11
2.3.8 Аэродром болон түүний орчмын торлосон зураг.....	11
2.3.9 ОБЖ-ыг сайжруулах зааврууд .....	11
2.4 Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагууд.....	11
<b>3. АЭРОДРОМЫН ОБЖ-ЫН АШИГЛАЛТ .....</b>	<b>12</b>
<b>4. ОБЖ-ЫН УДИРДЛАГА .....</b>	<b>12</b>
4.1 Бичиг баримтын бүтэц .....	12
4.2 ОБЖ-ын бичиг баримтын зохицуулалт .....	13
4.3 ОБЖ-ыг хянах .....	13
4.4 Бичиг баримтын хяналт .....	13
<b>ХАВСРАЛТ А - ОНЦГОЙ БАЙДЛЫН ТӨРЛҮҮД .....</b>	<b>14</b>
А.1 Танилцуулга .....	14
А.2 Агаарын хөлгийн онцгой байдал .....	14
А.2.1 Дотоодын бэлэн байдлын горим .....	14
А.2.2 Онцгой байдлын бүрэн хэмжээний бэлэн байдал .....	14
А.2.3 Агаарын хөлгийн осол.....	14
А.3 Анхаарах асуудлууд .....	15
А.3.1 Газар дээрх зөрчил .....	16
А.3.2 Хөдлөх чадвараа алдсан агаарын хөлөг .....	16
А.3.3 Усны орчим дахь аэродром .....	16
А.4 Онцгой байдлын аюулгүй байдал .....	16
А.4.1 Хорлон сүйтгэх ажиллагаа.....	16
А.4.2 Хууль бус эзэмшилт /барьцаалалт/.....	17
А.4.3 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх /агаарын хөлөг/ .....	17
А.4.4 Эзэнгүй ачаа .....	17
А.4.5 Сэжигтэй зүйл.....	18
А.4.6 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх /барилга байгууламж/ .....	18

A.4.7	Нийтийг хамарсан үймээн самуун .....	18
A.5	ОБ-ын бусад горимууд.....	19
A.5.1	Байгалийн гамшиг .....	19
A.5.2	Объектийн буюу газар дээрх гал.....	19
A.5.3	Аюултай бодис .....	19
A.5.4	Эмнэлгийн онцгой байдал .....	20
A.5.5	Нисэх буудалд гарсан зөрчил.....	20
A.6	Дэмжих төлөвлөгөө.....	20
A.6.1	Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө .....	20
A.6.2	Тусламж үзүүлэх журам .....	20
A.6.3	Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө .....	21
A.6.4	Хэвлэл мэдээллийн удирдлагын төлөвлөгөө .....	23
<b>ХАВСРАЛТ В - ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТ .....</b>		<b>23</b>
B.1	Холбооны хэрэгсэл.....	23
B.2	Холбооны систем.....	24
B.2.1	Каскадын систем /төлбөргүй дуудлага/.....	24
B.2.3	Онцгой байдлын түгшүүрийн автоматжуулсан систем.....	24
B.2.4	ОБ-ын Түгшүүрийн системийн мэдээллийн маягт .....	25
B.3	Жижиг аэродромуудыг анхаарах .....	28
B.4	Гуравдагч аэродром руу мэдээлэл өгөх .....	28
B.5	Зохицуулалт .....	28
B.5.1	Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС) .....	29
B.5.2	Онцгой байдлыг зохицуулах төв (ОБЗТ).....	30
B.5.3	Зөрчлийн удирдлагын штаб (ЗУШ).....	30
<b>ХАВСРАЛТ С - ЭМНЭЛГИЙН АНХААРАХ ЗҮЙЛС .....</b>		<b>31</b>
C.1	Эмнэлгийн тоног төхөөрөмжүүд.....	31
C.2	Ангилах болон эмнэлгийн тусламж.....	32
C.3	Амьд үлдэгсдийг халамжлах .....	33
C.4	Амь үрэгдэгсдийн асуудлыг зохицуулах .....	33
<b>ХАВСРАЛТ D - БОДИТ БАЙДАЛД ОЙРТУУЛСАН ОНЦГОЙ БАЙДЛЫН ДАСГАЛ СУРГУУЛИЛТ .....</b>		<b>34</b>
D.1	Зорилго.....	34
D.2	Бодит байдалд ойртуулсан онцгой байдлын дасгал сургуулилт.....	35
D.2.1	Онцгой байдлын дасгал сургуулилтын бэлтгэл .....	35
D.2.2	Онцгой байдлын дасгал сургуулилтын хүрээ .....	35
D.2.3	ОБ-ын дасгал сургуулилтыг төлөвлөх, хугацааг тогтоох.....	36
D.2.4	Оролцогсдод зохицуулалт хийж үр дүнг нэмэгдүүлэх.....	36
D.2.5	Бусад анхаарах зүйлс .....	36
D.3	Дасгал сургуулилтын дараах тайлан .....	37
<b>ХАВСРАЛТ E - БУСАД АНХААРАХ АСУУДЛУУД .....</b>		<b>37</b>
E.1	Угтагсад болон гашуудагчдыг зохицуулах.....	37

E.1.1	Угтагсад болон гашуудагчид.....	37
E.1.2	Аюулгүй байдал болон зориулалтын талбай.....	37
E.1.3	Мэдээлэлд нэвтрэх .....	38
E.1.4	Жижиг үйл ажиллагаа эрхлэгчид.....	38
E.2	Терминалын зохион байгуулалт .....	38
E.3	Ослын талбай - нотлох баримтуудыг хамгаалах .....	39
E.3.1	Нотлох баримтыг хамгаалах.....	39
E.3.2	Мөрдөх ажиллагаа болон сүйрлийн үлдэгдлийг цэвэрлэх.....	39
E.3.3	Сүйрэл .....	39
E.3.4	Хөнгөн агаарын хөлгийн осол.....	40
E.4	Хэвийн үйл ажиллагаанд эргэж орох - сэргээх үе шат.....	40
E.5	Бодит онцгой байдлын дараах тайлан .....	41
E.6	ОБЖ-ын тогтмол хяналт .....	41
<b>ХАВСРАЛТ F - ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛҮҮД.....</b>		<b>41</b>
F.1	Бичиг баримтууд .....	41

## 1. Танилцуулга

ИНД 139-ийн дагуу Аэродромын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь тогтмол шалгалт хийж сайжруулах шаардлагатай.

Аэродромын Онцгой Байдлын Журам /ОБЖ/-тай байна. Аэродромын үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангасан гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын Даргын тодорхойлсон шалгуурын дагуу холбогдох нисэхийн судалгаа, ОБЖ-тай байна. ОБЖ нь ИНЕГ-ын бүх шалгуур асуудлуудыг агуулсан байх шаардлагатай ба энэ нь гэрчилгээжсэн аэродромд тавигдах шаардлагаас үндэслэгдсэн байна. Эдгээр шаардлагууд нь Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ авахаас илүү төвөгтэй байж болохгүй.

ОБЖ нь Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага, Хавсралт 14, Боть 1-Аэродромын Төлөвлөлт болон Үйл ажиллагаа-ны шаардлагууд дээр үндэслэсэн байна. Хавсралт 14 нь аэродромын ОБЖ-ыг боловсруулахад шаардлагатай мэдээллүүдийг өгнө.

“Аэродромын Онцгой Байдлын төлөвлөлт нь аэродром дээр болон түүний орчимд онцгой байдал үүссэн үед түүнийг амжилттай давж гарах үүднээс холбогдох бэлтгэл ажлуудыг хийх үйл ажиллагаа юм. ОБЖ-ыг боловсруулах зорилго нь аюул, ослын үед түүнээс үүдэн гарах нөлөөллийг багасгах ялангуяа хүний амь аврах, нислэгийн үйл ажиллагааг үл тасалдуулах зэрэг ач холбогдолтой. ОБЖ нь ослын үед аэродромын орчим дахь байгууллагуудын туслалцаа, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, зохицуулалтыг бий болгоно”.

Энэхүү ЗЦ-д сайтар төлөвлөсөн ОБЖ-ыг боловсруулахын тулд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон Онцгой Байдлын Хороо тусламж үзүүлэх аргачлалууд болон цаашдын анхаарах асуудлуудын эмхэтгэлийг үзүүлсэн болно.

Үүний зорилго нь иргэний нисэхийн орчин, өөр өөр зэрэглэл бүхий аэродромуудын ОБЖ-ыг боловсруулахад гарах асуудлуудыг үзүүлэхэд оршино. ОБЖ-ын хүрээ нь аэродром дээр явагдаж буй нислэгийн үйл ажиллагааны төрлөөс хамаарна. Энэхүү ЗЦ-ын зарим хэсэг заалтууд бүх аэродромууд дээр мөрдөгдөх боломжгүй байх талтай. ОБЖ нь тухайн аэродромын үйл ажиллагааны зэрэглэл дээр тулгуурлагдан боловсруулагдсан.

ОБЖ-ыг ИКАО Док 9137-Нисэх буудлын үйлчилгээний гарын авлага, Хэсэг 7 - Нисэх буудлын ОБЖ-ыг төлөвлөх нь мөн бусад иргэний нисэхийн ОБЖ-г төлөвлөх журам, заавар, үйл ажиллагааны туршлага зэргээс үндэслэн боловсруулна.

### 1.1 Зорилго

Аэродромын Онцгой Байдлын төлөвлөлт нь аэродром дээр болон түүний орчимд онцгой байдал үүссэн эсвэл аэродромоос хол зайд агаарын хөлгийн осол гарсан үед түүнийг амжилттай давж гарах үүднээс холбогдох бэлтгэл ажлуудыг хийх явдал юм.

Аэродром орчмын газарзүйн байрлал болон ялангуяа аль хэсэг нь аэродромын бүсэд хамаарах, аль хэсэг нь үл хамаарах, алслагдсан бүс болохыг тодорхой заасан байх бөгөөд эдгээр бүсүүдэд онцгой байдлын үеийн ямар статусаар ажиллахыг ОБЖ-д заасан байх нь чухал. Гэхдээ бичиг баримтын статус нь ямар нэгэн ослын тохиолдолд аэродромын байгууллагуудын ОБЖ-ын зорилгод нийцсэн үнэлж баршгүй оролцоог хаах утга санааг үл агуулсан байна.

Онцгой байдлын нөхцлүүд нь тухайн тохиолдолд болон дараа нь аэродромын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлэх магадлалтай байдаг. Аэродромын ОБЖ-ын зорилго нь ослын үед хүн гэмтэх, бэртэх нөлөөлөл, эд хөрөнгийн хохирлын хэмжээг бууруулах юм. Үүнд 2 үндсэн зүйл ордог.

Эхний зорилго нь хүний амь нас эрсдэх тохиолдлыг багасгах. Онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаалсан шууд авах арга хэмжээ болон осолд шууд /хувь хүмүүсийн авах арга хэмжээ/эсхүл шууд бус /нисэх буудал доторхи хүмүүс/ хамааралтай хүмүүсийг хамгаалах нь ОБЖ-ын нэн тэргүүний зорилт байна.

Дараагийн зорилго нь аэродромыг аль болох түргэн хэвийн ажиллагаанд эргүүлж оруулах. Тоног төхөөрөмжийн ажиллагаа, эд хөрөнгийг сэргээх эсхүл тэдгээрийг ослын нөлөөллөөс хамгаалах нь ОБ-ын дараа хэвийн үйл ажиллагаанд эргэж ороход маш чухал.

Аэродромын ОБ-ын үед авах арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан хэдий ч хэвийн үйл ажиллагаанд орно гэсэн үг биш учир нь аэродромын ОБ-тай холбогдсон маш олон төрлийн авах арга хэмжээ байсаар байна. Жишээ нь: уулзагсад болон гашуудагсдад анхаарал тавих, авсан арга хэмжээг тайлагнах гэх мэт. ОБ-ын зарлагдсан түвшнээс хамаарсан авах арга хэмжээнээс шалтгаалаад үйл ажиллагааны түр зогсолт хийх нь түгээмэл байдаг.

## 2. Аэродромын Онцгой байдлын журам

### 2.1 Танилцуулга

ИНД 139.57 - Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ

ИНД 139.25 - Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлага хангасан гэрчилгээ

ИНД 139-д өргөдөл гаргагч нь гэрчилгээ авахаас өмнө холбогдох шаардлагуудыг хангасан байхыг заасан. Энэхүү ЗЦ-д гэрчилгээ эзэмшигчийн хэрэгжүүлэх арга хэмжээнүүд заагдсан бөгөөд өргөдөл гаргагчийн талаар огт дурдагдаагүй, учир нь гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг анх авах үед тавигдсантай ижил шаардлагуудын хэрэгжилтийг үргэлжлүүлэн хангах үүрэгтэй.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигчийн бүх шаардлагууд тусгагдсан бөгөөд зөвхөн ИНЕГ-ын Даргын гаргасан шаардлагууд нь аэродромын үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангасан гэрчилгээ авахад хэрэглэгдэнэ.

### 2.2 Аэродромын Онцгой байдлын журмын шаардлагад

Хүснэгт 1-д Аэродромын ОБЖ-ын үндсэн шаардлагуудыг үзүүлэв.

Хүснэгт 1 - Аэродромын ОБЖ-ийн шаардлагууд

<i>Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ</i>	<i>Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлага хангасан гэрчилгээг зүйлчлэх</i>
Аэродромын ОБЖ шаардагдсан <i>ИНД 139.57 (а)</i>	ИНЕГ-ын Дарга шаардсан бол ОБЖ-тай байна. <i>ИНД 139.25</i>
Тайлбар бичигт ОБЖ-ын агуулагдсан байна. <i>ИНД 139.77(а)(7)</i>	Тайлбар бичиг нь ОБЖ-д хамаарах эрсдэлүүдийг зохицуулах журмууд болон шаардлагуудыг багтаасан байна. <i>ИНД 139.417(б)(2)</i>
Continue to meet the standards and comply with the requirements of Subpart B. <i>ИНД 101(4)</i>	Тайлбар бичигт бүх үйл ажиллагаа, төлөвлөгөө, систем болон хөтөлбөрүүдийг нарийвчлан тусгасан байна. <i>ИНД 139.451(2)</i>

### 2.3 Аэродромын Онцгой байдлын журмын агуулга

#### *ИНД 139.57(б)*

ОБЖ-д байх ёстой олон асуудал байдаг. Тэдгээрт доорх зүйлүүд орно. Үүнд:

#### 2.3.1 Онцгой байдлын төрлүүд

##### *ИНД 139.57(б)(1)*

ОБЖ нь аэродром болон түүний орчимд онцгой байдал үүссэн үед хариу арга хэмжээ авах үүрэгтэй байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, зохион байгуулалтыг хангах үүрэгтэй.

ОБ-ын нөхцлүүд нь журмыг яаж хийснээс шалтгаалаад ерөнхийдөө 2 бүлэгт хуваагддаг. Агаарын хөлөг оролцсон болон оролцоогүй. ОБ-ын өөр нөхцөлүүд ч бас байдаг. Шаардлагатай бол ОБ-ын нөхцлийн аюулгүй байдал нь тусдаа бүлэгтэй байж болно.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь мөн ажлын бус цагт ОБ-ын нөхцөл үүссэн тохиолдолд авах арга хэмжээг боловсруулна. Ялангуяа ажлын бус цагийн ОБ-д хамгийн түрүүнд ажиллах шаардлагатай хүмүүсийн жишээ нь нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв болон гал унтраах албаны ажилтнууд гэх мэт болно.



Энэхүү ажлын хүрээнд терминалын ханан дээр онцгой байдлын албадуудтай хэрхэн холбоо барих болон аэродромын нэр, байршил зэрэг өөр ямар мэдээллүүдийг өгөх талаар заасан тэмдэг байрлуулсан байна.

Энэхүү ЗЦ-ын хавсралт А-д анхаарч үзэх ёстой ОБ-ын төрлүүдийг үзүүлсэн болно.

### **2.3.2 Онцгой байдлын үед яаралтай авах арга хэмжээний журам**

*ИНД 139.157 (б)(2)*

ОБ-ын төрөл бүр нь хариу арга хэмжээ авах албадуудтай холбоо барих журмууд болон тэдгээрт хэрэгцээт түгшүүрийн дохио өгөх зэрэг үйл ажиллагааг нарийвчлан багтаасан байна. Үүнд түгшүүр өгөх системийн бүдүүвч болон хариу үйлдлийн түвшинг оруулна.

Энэхүү ЗЦ-ын хавсралт Б-д холбооны систем болон ОБЖ-ыг хариуцсан ажилтныг томилно. Ингэснээр хариуцах эзэнтэй болгохоос гадна журам нь сайжрагдаж байх нөхцөл бүрдэнэ.

ОБЖ-ын төлөвлөлт нь маш чухал юм. ОБЖ-ыг үр дүнтэй, ашигтай, ойлгомжтойгоор төлөвлөх нь маш чухал.

Хэрэв аэродромын ойртолтын болон хөөрөлтийн бүс нь их хэмжээний усан дээр эсхүл аэродром нь томоохон хэмжээний ус, нуур, цөөрмийн орчимд байрладаг бол тусгайлсан үйл ажиллагаа, мэргэжлийн байгууллагатай байхыг ОБЖ-д заасан байна. Эдгээрт эргийн хамгаалалтын алба, шумбагчид, завьчид зэрэг тухайн орон нутгийн мэргэжлийн албатай хамтарч ажиллаж болох боломжийг мөн заасан байна. Дээрх авран хамгаалах мэргэжлийн байгууллагууд нь ОБ-ын нөхцлийн ердийн сорил, дадлагад хамрагдсан байна.

### **2.3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал**

*ИНД 139.57(б)(3)*

Аэродромын онцгой байдлын төрөл, авах арга хэмжээ, хамрагдах ажилтнуудын хувьд хоорондоо харилцан адилгүй. ОБЖ-д түүнд хамрагдах ажилтан нэг бүрийн оролцоо, авах арга хэмжээнүүдийг тодорхой заасан байх нь чухал. Энэ нь мөн ОБ-ийн үед оролцогч байгууллага бүрийн авах арга хэмжээ болон ОБ-ын нөхцөл дуусах үеийн үйл ажиллагааг багтаасан байвал зохино.

### **2.3.4 Байгууллагуудын үүрэг хариуцлага болон хийх ажлууд**

*ИНД 139.57(б)(4)*

Оролцогч байгууллага бүр нь үүссэн онцгой байдлыг хяналтандаа авах арга хэмжээ, үйл ажиллагааны талаарх ойлгомжтой журмуудтай байна. Онцгой байдлын нөхцлийн үед авах арга хэмжээг бодитойгоор хангах үүднээс оролцогч байгууллагуудын үүрэг маш нарийн заагдсан байна. Доор заагдсан нэгжүүдийг багтаасан аэродромын үндсэн байгууллагууд:

**Аэродром дээр** - Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв, эрэн хайх авран хамгаалах алба болон нисэх буудлын захиргаа, эмнэлэг, түрээслэгчид, агаарын тээвэрлэгчид, аюулгүй байдлын албадууд, хилийн хяналтын алба, цагдаа

**Аэродромын гадна** - Галын алба, цагдаа, түргэн тусламж, эмнэлэг, зэвсэгт хүчин, онцгой байдлын алба, орон нутгийн захиргаа, эрэн хайх авран хамгаалах алба зэрэг орно.

ОБ-ын үеийн үед авах арга хэмжээний журам, төлөвлөгөөнд хүний хүчин зүйлүүдийн үндсэн нөхцлүүдийг тооцсон байна. Үүнд ажилтнууд нь ОБ-ын үед өөрсдийн үүрэг, бусад хүмүүс, машин тоног төхөөрөмж, мэдээллийн сурвалжууд, хүрээлэн буй орчинтой хэрхэн зохицох болон хүний хийх боломжгүй зүйлсийг тодорхойлох зэргийг багтаасан байвал зохино.

*ИКАО Док 9683 Хүний хүчин зүйлийн талаарх сургалтын заавар* нь иргэний нисэхэд холбоотой хүний хүчин зүйлийн талаарх баримт бичгүүдийн нэг юм. Хүний хүчин зүйлсийн жишээнүүд -

- Үйл ажиллагаа эрхлэгчид болон байгууллагуудад зориулсан хяналтын хуудсыг боловсруулах. Энэ нь хувь хүнийг тодорхой зам, төлөв рүү хөтөлнө.
- Онцгой байдлыг зохицуулах төв (ОБЗТ)-ийг ойлгомжтой хаягжуулах болон тэмдэгжүүлэх эсхүл эргэлзээ төрүүлэхүйц зүйлсийг багасгах үүднээс тоног төхөөрөмжүүдийг удирдах, хянах. Энэ нь бодох үйл ажиллагаа болон буруу шийдвэр гаргах боломжийг багасгадаг.
- ОБЖ-ыг хариуцах ажилтныг томилох. Энэ нь ОБЖ-ыг эзэнтэй болгохоос гадна байнга шинэчлэгдэж байх боломжийг бий болгодог.
- ОБЖ-ын бүрдэл, загвар нь маш чухал. Энэ нь ОБЖ-ыг үр дүнтэй, бүтээмжтэй болон ойлгомжтойгоор боловсруулахад чухал үүрэгтэй болно.

Хэрэв аэродромын ойртолтын болон хөөрөлтийн бүс нь их хэмжээний усан дээр эсхүл аэродром нь томоохон хэмжээний ус, нуур, цөөрмийн орчимд байрладаг бол тусгайлсан үйл ажиллагаа, мэргэжлийн байгууллагатай байхыг ОБЖ-д заасан байна. Үүнд эргийн хамгаалалтын алба, шумбагчид, завьчид зэрэг тухайн орон нутгийн мэргэжлийн албатай хамтарч ажиллаж болох боломжийг мөн заасан байна. Эдгээр авран хамгаалах мэргэжлийн байгууллагууд нь ОБ-ын нөхцлийн ердийн сорил, дадлагад хамрагдсан байна.

### **2.3.5 ОБ-г зохицуулах төв болон Удирдлагын штабын үүрэг**

*ИНД 139.57(б)(5)*

Олон улсын нисэх буудал нь ОБ-ын үед ашиглах зорилгоор байнгын ОБ-ыг зохицуулах төв болон удирдлагын штабтай байна. ОБ-ыг зохицуулах төв нь аэродромын барилга байгууламжийн нэг хэсэг байх бөгөөд ОБ-ын нөхцлийг ерөнхийд нь удирдах, зохион байгуулах болон ОБ-ын үед авах арга хэмжээний чиглэлийг гаргах үүрэг бүхий ажилтнуудтай байна. Удирдлагын төв нь ОБ-ын нөхцөл үүссэн байрлал руу түргэн хугацаанд нүүх, шилжих боломжтой байх, шаардлагатай бол тухайн орчмын байгууллагууд үүссэн ОБ-ын нөхцөлд хариу үзүүлэх арга хэмжээг зохицуулах үүрэгтэй. Онцгой байдлыг зохицуулах төв болон удирдлагын штабын үйл ажиллагааг хянах, удирдах ажилтнуудыг томилсон байна.

Энэхүү ЗЦ-ын Хавсралт - Б ОБ-ыг зохицуулах төв болон Удирдлагын штабын үүрэг шаардлагуудыг хэрэгжүүлэх зааврыг агуулсан.

### **2.3.6 Эмнэлгийн болон бусад боломжит тоног төхөөрөмж, техникүүдийн байршил болон тодорхойлолт**

*ИНД 139.57(б)(6)*

ОБЖ нь дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд:

- Аэродромын ОБ-ын боломжит тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн байрлал, төрөл

- Эмнэлгийн хангалт болон олон улсын нисэх буудлын зөөврийн тоног төхөөрөмж
- Хөдлөх чадвараа алдсан болон осолд орсон агаарын хөлгийг зөөх, шилжүүлэхэд шаардлагатай төхөөрөмжүүд

Эмнэлгийн тоног төхөөрөмжүүд нь энэхүү ЗЦ-ын Хавсралт С-д заагдсан болно.

### **2.3.7 Онцгой байдалд оролцогч байгууллагуудын холбоо барих мэдээлэл**

*ИНД 139.57(б)(7)*

ОБ-ын үед оролцох байгууллагуудын холбоо барих мэдээллүүд нь ОБЖ-д мэдээлэгдсэн байх бөгөөд тогтмол шинэчлэгдэж байх ёстой.

### **2.3.8 Аэродром болон түүний орчмын торлосон зураг**

*ИНД 139.57(б)(8)*

Аэродромын торлосон зураг болон аэродромын хүрээлэн буй орчны торлосон зураг нь арга хэмжээ шаардлагатай байгууллагуудад осол гарсан газрын байршлыг заахад тусладаг. Эдгээр торлосон зургууд нь шаардлага хангахуйц масштабтай байх ба нарийвчлал нь уншихад хялбар, тодорхойгүй байдал үүсэхээргүй байна. Эдгээр нь ОБ-ын үед шаардлагатай байгууллагуудыг ОБ-ын бодит байрлал руу чиглүүлэхэд туслахад шаардлагатай. Торлосон зургийн тайлбарууд нь хүн бүрт эргэлзээ үүсэхээс сэргийлсэн онцгой байна.

### **2.3.9 ОБЖ-ыг сайжруулах зааврууд**

*ИНД 139.57(б)(9)*

ОБЖ нь үр дүнтэй бөгөөд зайлшгүй орох ёстой заалтуудыг энэхүү журамд багтаасан гэдгийг баталгаажуулсан байна.

ОБЖ-аар гүйцэтгэх үүрэг, хариуцлага нь заагдсан ажилтан нь өөрсдийн гүйцэтгэх үүргийг мэддэг байх ба холбогдох сургалтанд хамрагдсан, хөтөлбөрүүд нь үе шатны туршилтууд хийгдсэн, ОБ-ын дадлага болон бодитоор үүссэн нөхцлийн дараа хянагдсан, илэрсэн үл тохирлууд нь засварлагдсан байх ёстой. Мөн ОБЖ-д хамааралтай бүх байгууллага, хувь хүмүүсийн зохицуулалт хийгдсэн байна. Хэсэг 3-т эдгээр шаардлагуудыг дэлгэрэнгүй заасан болно.

Энэхүү ЗЦ-ын Хавсралт Д -д ОБЖ-ыг шалгах загварчилсан дасгалын зааварчилгаа өгөгдсөн болно.

## **2.4 Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагууд**

*ИНД 139.57(ц)*

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ОБЖ-ыг боловсруулахад холбогдох бүх байгууллага, хувь хүмүүсийн оролцоог тусгасан байна. ОБЖ-д үүрэг хариуцлага хүлээсэн бүх хүчний байгууллагууд, аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгчид, эрэн хайх болон авран хамгаалах байгууллагууд, эмнэлгийн байгууллага болон ажилтан, аэродромын үндсэн түрээслэгчид болон бусад бүх хүмүүс үүнд орсон байна.

Байгууллага болон үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын харилцан ажиллагаа нь чухал байдаг. Хэрэв ОБ-ыг зохицуулах төв ажилласан бол заагдсан байгууллага бүрийн холбооны төхөөрөмжийн тоноглолт болон шийдвэр гаргалтыг баталгаажуулна.

ИНД 139-ийн шаардлагын дагуу ОБЖ-ыг боловсруулах, ашиглах нь Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг бол зохион байгуулалттай арга хэмжээ авах бодит үйл ажиллагаа болон туслах арга хэмжээнүүдийг ОБ-ын хороо гаргах нь шилдэг арга байдаг. Аэродромын ОБ-ыг төлөвлөх хороо нь орон нутгийн байгууллагууд эсхүл онцгой байдлын албадуудаас байгуулагдсан ОБ-ын томоохон нэгдлийн нэг хэсэг байх

боломжтой. Аэродромын ОБ-ыг төлөвлөх хороо нь нисэх буудалд, аэродром дотор болон гадна эсхүл түүний орчимд үүссэн ОБ-ын нөхцлүүдэд авах арга хэмжээ, сэргээх ажиллагаа болон шаардлагатай хугацаанд, зохион байгуулалттай боловсруулсан төлөвлөгөөг бий болгох үүрэг хүлээсэн байна.

Аэродромын ОБ-ыг төлөвлөх хороо нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид нэмэлтээр цагдаа, гал унтраах алба, эмнэлэг, эрэн хайх авран хамгаалах алба, агаарын тээвэрлэгч эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэгч болон ОБ-ын нөхцлийн талаар мэдлэгтэй эсхүл туслалцаа үзүүлэх боломжтой бусад байгууллагуудаас ихэвчлэн бүрдэнэ. Жишээ нь орон нутгийн ОБ-ыг зохицуулах төв, эрүүл мэндийн байгууллага, хүмүүнлэгийн тусламжийн байгууллагууд гэх мэт орно.

### 3. Аэродромын ОБЖ-ын ашиглалт

*ИНД 139.109*

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч үр дүнтэй үйл ажиллагаа бүхий ОБЖ-тай байна. ОБЖ нь дараах шаардлагуудыг зайлшгүй агуулсан байна. Үүнд:

- a. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ОБЖ-д орсон үүрэг хариуцлага бүхий ажилтан нь өөрийн биелүүлэх арга хэмжээг мэддэг, шаардлагатай сургалтанд хамрагдсан байх.
- b. ОБЖ-ыг шалгах ажиллагааг дараах 2 аргаар хийнэ. Үүнд:
  - i. Аэродромын ОБ-ын бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг хамгийн багадаа 2 жилд нэг удаа хийх, бүрэн хэмжээний сургуулилтын үед илэрсэн дутагдлуудыг зассан байхыг баталгаажуулах үүднээс тусгай ажиллагаа явуулах.
  - ii. Цуврал шалгалтын үе шатууд нь 3 жил тутамд хийгдэх, ОБЖ-ыг мөрдөж эхэлснээс хойш 3 жилээс илүүгүй хугацанд бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг хийх.
- c. Онцгой байдлын бодит тохиолдол болон сургуулилт бүрийн дараа хянах, илэрсэн дутагдалтай зүйлсийг засах.
- d. Хүчний байгууллагууд, аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчид, эрэн хайх авран хамгаалах албадууд, эмнэлгийн байгууллага, хувь хүн, аэродромын үндсэн түрээслэгчид зэрэг ОБЖ-д заагдсан үүрэг харуцлага бүхий бүх байгууллага, хувь хүмүүсийг зохион байгуулсан байна.

Энэхүү ЗЦ-ын Хавсралт Д -д ОБ-ын үед хийх загварчилсан дасгалын зааварчилгаа өгөгдсөн болно.

### 4. ОБЖ-ын удирдлага

#### 4.1 Бичиг баримтын бүтэц

ОБЖ нь тухайн орон нутгийн шаардлагад нийцсэн, аэродромын үйл ажиллагааны төрлөөс хамаарсан бүтэцтэй байна. Учир нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн олон төрлийн ажлын хүрээнээс шалтгаалж ОБЖ-ын шинж байдлыг харуулсан тодорхой стандарт байдаггүй. Гэсэн хэдий ч ОБЖ нь аэродромын үйл ажиллагааны төрлөөс хамаарсан түвшинд ИНД- 139-ийн шаардлагуудыг хангасан байна.

ОБЖ нь ерөнхийдөө хэсэг болон дэд хэсэгт хуваагддаг, үндсэн хоёр хэлбэрийн нэгийг нь дагадаг. Үүнд:

- a. Онцгой нөхцлийн үед тодорхой үүрэг, хариуцлага бүхий байгууллага бүр нь бүрэн хэмжээний төлөвлөгөө бүхий өөрийн хэсэгт ОБ-ын төрөл бүрт авах арга хэмжээг багтаасан дэд хэсгүүдийн хамт орсон байх;
- b. Бүрэн хэмжээний төлөвлөгөө нь ОБ-ын төрөл бүрт шаардлагатай арга хэмжээг үзүүлсэн хэсгүүдэд, энэхүү төлөвлөгөөний дагуу байгууллага бүрийн авах арга хэмжээ нь дэд хэсгүүдэд орсон байхаар боловсруулагдана.

## 4.2 ОБЖ-ын бичиг баримтын зохицуулалт

ОБЖ-ын зохицуулалт болон хуваарилалттай холбоотой нилээд хэмжээний асуудлууд үүсдэг. ОБЖ-ын хамгийн түгээмэл асуудлууд нь нэлээд хэмжээний боловсруулагдах хуудас болон тогтмол шинэчлэгдэж байх шаардлага юм. Бичиг баримтууд нь өөрөө зардал болохоос гадна удирдлагын үйл ажиллагаа болон ОБЖ-ын шинэчлэлт, өөрчлөлтүүдийн зардал нь дарамт болдог талтай.

Энэхүү асуудлыг шийдвэрлэх нэг арга нь ОБЖ-ын цувралын тоог багасгах болно. Байгууллагууд ОБЖ-аас зөвхөн өөрсдийн холбогдох хэсгүүдийг ихэвчлэн шаарддаг. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд зарим нисэх буудлууд тухайн байгууллагад хамааралтай асуудлуудыг хэсэгчилж болон тохируулж гаргасан ОБЖ-ын багцыг тарааж эхэлсэн. Энэ нь нисэх буудлын операторын холбогдох байгууллагуудад тараах ёстой хуудсын хэмжээг багасгасан болно.

Мөн энэхүү асуудлыг шийдэх нэг арга зам бол цахим ОБЖ хийх юм. Ялангуяа хатуу дискэнд хуулбарлах, цахим шуудангаар болон аэродромын үйл ажиллагаа хамгаалалттай цахим хуудсаар тарааж болно. Оролцогч байгууллагууд нь өөрсдийн холбогдох хэсгийг хэвлэн авч аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн олгосон ОБЖ-ын хавтаст түүвэрлэн оруулна. Мөн өөр нэгэн шаардлагатай ажил нь энэхүү журмыг тогтмол шинэчлэх асуудал байдаг. Холбоо барих утасны дугаар, холбогдох хүүмүүсийн хаяг, байгууллагын бүтэц дэх албан тушаал зэрэг бүх зүйлс нь хуваарийн дагуу солигдож байна. Холбоо барих хаягийг хамгийн багадаа жилд 1 удаа хянаж, баталгаажсан эсэхийг тогтоосон байна.

## 4.3 ОБЖ-ыг хянах

Аэродромын ОБЖ-ын хамгийн чухал хэсэг нь онцгой нөхцөлд авах арга хэмжээнүүдийг хянах юм. ОБЖ-ын хяналт нь дараах тохиолдлуудад хийгдэнэ. Үүнд:

- Хуваарьт төлөвлөгдсөн үйл ажиллагаа;
- ОБ-ын сургуулилт;
- Бодит ОБ-ын дараах тайлан;
- Бусад газруудаас авсан судалгаа.

ОБЖ-ын үр дүнг нэмэгдүүлэх үүднээс аливаа өөрчлөлтүүд хийгдэж байх ёстой.

## 4.4 Бичиг баримтын хяналт

ОБЖ нь дараах зүйлсийг баталгаажуулах үүднээс хянагдаж байна. Үүнд:

- Журманд заагдсаны дагуу үүрэг хариуцлага хүлээх бүх байгууллага болон хүмүүст ОБЖ-ын холбогдох сүүлчийн хувилбар хэсгүүд нь байх ёстой.
- Бүх хуучин хэсгүүдийг нэн даруй хасах ёстой.
- ОБЖ-ын сүүлчийн хувилбар нь өмнөх хүчингүй болсон хувилбарын хэрэглээг байхгүй болгож байгаа эсэх нь тодорхойлогдсон байна.

## Хавсралт А - Онцгой байдлын төрлүүд

### А.1 Танилцуулга

ОБЖ-д тусгагдсан байх ёстой Онцгой байдлын нөхцлүүдэд тооцогдох шаардлагатай жагсаалтыг дор үзүүлэв. Тодорхой болгох үүднээс ОБ-ын төрлүүдийг 3 төрөлд хуваасан бөгөөд үүнд агаарын хөлгийн, аюулгүй байдлын, бусад төрлийн гэх мэт.

### А.2 Агаарын хөлгийн онцгой байдал

Агаарын хөлгийн нисгэгчид зориулагдсан аэродром дээрхи ОБ-ын мэдээллийг НМЭ /AIP/, ENR 1.1 -д, ОБ-ын горимын талаархи мэдээллүүд болон тэдгээрийг нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд хэрхэн мэдээллэх талаар дэлгэрэнгүй үзүүлсэн.

#### А.2.1 Дотоодын бэлэн байдлын горим

Аюулгүйн буулт үйлдэхэд огт саадгүй боловч өөр ямар нэгэн асуудал үүссэн гэж сэжиглэгдсэн эсхүл тогтоогдсон агаарын хөлөг аэродром руу ойртол үйлдэж буй бол дотоодын бэлэн байдлын горимыг зарладаг. ДОТООДЫН БЭЛЭН БАЙДЛЫН ГОРИМ-ийг зарлах үед аэродромын онцгой байдлын албадуудыг бэлэн байдалд шилжүүлэх бөгөөд аэродромын бус албадууд нь мэдээлэл авсан боловч өөрсдийн байршдаг цэгүүд дээр бэлэн байх горимд шилжүүлнэ.

Мөн бэлэн байдлын бусад үйл ажиллагаа хангагдсан эсэхийг баталгаажуулна.

#### А.2.2 Онцгой байдлын бүрэн хэмжээний бэлэн байдал

Ослын аюул бүхий асуудал үүссэн гэж сэжиглэгдсэн эсхүл тогтоогдсон агаарын хөлөг аэродром руу ойртолт үйлдэж буй үед ОБ-ын бүрэн хэмжээний бэлэн байдлын горимыг зарлана. БҮРЭН ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН ГОРИМ-ийг зарлах үед түргэн тусламж болон эмнэлгийн үйлчилгээ, цагдаа, галын алба гэх мэт аэродромын болон орчмын онцгой байдлын бүх албадууд, тоног төхөөрөмжүүд аэродромын уулзах бүс буюу цаашид осол зөрчлийн үед цугларах эсхүл бөөгнөрөх бүс болох боломжтой цэгт бэлэн байдалд байна. Энэ үед мөн гэмтэж бэртсэн хүмүүсийг эмнэлгүүд хүлээн авахад бэлэн байлгах, ОБ-ын тээврийн хэрэгслүүдийг саадгүй явуулах үүднээс замын хөдөлгөөний хяналтын албыг бэлэн байлгах түгшүүрийг өгдөг болно.

Мөн бэлэн байдлын бусад үйл ажиллагаа хангагдсан эсэхийг баталгаажуулна.

#### А.2.3 Агаарын хөлгийн осол

Аэродром дотор болон түүний орчимд агаарын хөлгийн осол эсхүл сүйрэл гарсан үед ослын горимыг зарлана. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ ЭСХҮЛ СҮЙРЭЛ аль ч байрлалд гарч болно. Ослын байрлалаас хамаараад аэродромын байгууллагуудын авах бодит арга хэмжээнүүд нь өөр өөр байна.

Энэ үеийг ОБЖ-ын төлөвлөлтөнд ИКАО-аас 2 ерөнхий байршлыг сонгож тооцохоор заасан байдаг. Энэ нь нисэх буудлын дотор болон гадна гэсэн нөхцөлтэй. Нисэх буудлын гадна гэдэг нь аэродромыг хүрээлэн буй газарзүйн нөхцлөөс хамаарах бөгөөд энэ нь цаашдаа нисэх буудлын гаднах хуурай болон усан дээр гарсан осол гэж хуваагдана.

Аэродромын орчмын газарзүйн байршлаас хамаарсан ослын горимуудын тогтоосон төрөл, мөн ослын үед авах арга хэмжээний статусыг ОБЖ-д заасан байх нь чухал юм. Жишээ нь зарим аэродромууд нь аэродромын дотор гэдгийг түүнийг хүрээлэн буй периметрийн хашаагаар тооцдог. Зарим нь ХБЗ-ны төгсгөлийн цэгүүдээс 2 тийш /гадна/ 300м-ийн өргөнтэй нийт 1000м хэсэгт буюу ойртолтын болон хөөрөлтийн бүсийг оролцуулж тооцдог.

Нисэх буудлын гадна гэдэг тодорхойлолт нь өөр өөр байх боломжтой. ИКАО-ийн шаардлагаар ОБЖ-ийн хүрээнд нисэх буудлын орчим, эргэн тойронд 8 км радиус бүхий талбайг тооцсон байна гэж заадаг. 8 км-ийн энэхүү бүсэд онцгой байдлын бүрэн арга хэмжээ авах талаар зөвхөн ОБЖ-д заах нь боломжгүй байх магадлалтай. Хэрэв энэхүү бүс нь хотын төвийн барилгажсан бүс бол иргэний хамгаалалт, цагдаа, гал унтраах албадууд илүү оролцоотой байна.

Энэхүү зохицуулалт нь алслагдсан бүсүүдэд мөн адил хамаарна. Хэдийгээр ИКАО шаардаагүй боловч энэ нь ОБЖ-ын нэг бүрдэл хэсэг болсоор байна. Ослын газар дээр ажиллах байгууллага хоорондын зохион байгуулалтыг хийхэд болон аэродромын нөөцийг тухайн осолд хамруулах, эс хамруулах талаар ОБЖ нь үндсэн бичиг баримт болж чаддаггүй тул аэродром дээр байгууллагуудын оролцоо, идэвхижүүлэлтийг шаардсан ОБЖ-ын заалтууд байх ёстой. Аэродромоос хол зайд үүссэн агаарын хөлгийн ослын үед авах арга хэмжээний хүрээ багасах магадлалтай бөгөөд энэ нь тусдаа ОБЖ-тай байна. Агаарын хөлгийн ослын үед анхаарах өөр нэг асуудал нь цэргийн агаарын хөлөгтэй хамтран тусгай ажиллагаа боловсруулах ажил юм. **Онцгой байдлын ерөнхий газар** нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид ослын тохиолдолд авах арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөхөд туслах зорилготой.

### **А.3 Анхаарах асуудлууд**

Төлөвлөлтийн арга хэмжээнүүдээс хамаарч шаардагдах зүйлсийн жишээнүүд нь

- Агаарын хөлөг хөөрсөн болон буух ёстой байсан аэродром дээр цугларсан уулзагсад болон гашуудагсад, ялангуяа, тэдгээрийн хамаатан саднууд болон хэвлэл мэдээлэлийн зэрэг хүмүүс. Тэрчлэн терминалын зохион байгуулалтын ажлуудад анхаарах ёстой.
- Ослийн нөхцөл нь тодорхойгүй байх хугацаанд анхаарал тавих үүднээс хамаатан садан болон бусад хүмүүст зориулсан тусгайлсан бүс гаргах.
- Нислэгийн мэдээллийн дэлгэцүүдээр тухайн нислэгтэй холбоотой мэдээллийг харуулж байх.
- Хэвлэл мэдээллийн зохицуулалт болох хяналт.
- Гаднаас ирэх асуулт, хүсэлттэй холбоотойгоор холбооны сүлжээнд хэт ачаалал үүсэх.
- Агаарын тээвэрлэгчдийн холбоо, логистикийн туслалцаа үзүүлэх.
- Осолд нэрвэгдсэн агаарын хөлгийн багийг зорчигчоос тусгаарласан зорчигчид болон агаарын хөлгийн багийг байрлуулах газраар хангах.
- Аэродромыг хаах болон хязгаарлалт хийх NOTAM мэдээг зарлах, агаарын тээвэрлэгчдийн холбоо болон ИНЕГ-аас агаарын зайд хязгаарлалт хийх.
- Агаарын хөлгийн бүрэлдэхүүн, зорчигчдыг осол болсон газраас өөр газарт буюу ослын талбар үл харагдах байрлалд нүүлгэх, бүх хүмүүсийг бүртгэж, тоолсон эсэхийг бататгах.
- Осолд нэрвэгдэгсэдийг тусгаарласан байранд байлгах буюу шаардлагатай хэрэгслүүд, утсан холбоо, интернетийн холболт гэх мэт зүйлсээр хангах.

- Эмнэлгийн байгууламжуудад орох түргэн тусламж, эмнэлэг болон тээвэрлэх хэрэгсэл болох автобус, нисдэг тэрэг зэргийг бэлтгэх.

### **А.3.1 Газар дээрх зөрчил**

Онцгой байдлын энэ горим нь агаарын хөлөгт хамаарах бөгөөд газарт байх үед гарсан тохиолдлыг хамруулж үзнэ. Дараах нөхцөл байдлууд энэ тохиолдлын жишээ болох бөгөөд үүнд газарт байсан агаарын хөлөгт ихэвчлэн хэт халсан тоормозны систем, агаарын хөлөг болон тээврийн хэрэгсэл бусад барилга байгууламжуудтай мөргөлдөх зэргээс шалтгаалан гал гарах зэрэг орно.

### **А.3.2 Хөдлөх чадвараа алдсан агаарын хөлөг**

ОБ-ын энэхүү горимд аэродромын хөдөлгөөний бүсэд явж байсан агаарын хөлөг хучилттай талбайгаас гарах эсхүл дугуй буудах гэх мэт асуудлаас шалтгаалж хөдлөх чадвараа алдах зэрэг орно. Энэхүү горимоор агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагааг идэвхижүүлнэ. Агаарын хөлгийг сэргээх горим нь ослын үед ОБЖ-ын сэргээх горимын дагуу автоматаар хэрэгжиж эхэлнэ.

### **А.3.3 Усны орчим дахь аэродром**

Аэродром нь томоохон хэмжээний ус болох далай, тэнгис эсхүл нуурын орчимд ойр байрласан бол агаарын хөлөг усанд осолдсон тохиолдолд хэрэгжүүлэх эрэн хайх, авран хамгаалах тусгай заалтууд боловсруулагдсан байна. Энэхүү ажиллагаанд усан онгоц, завь, усанд хөвөгч зэрэг нэмэлт аврах хэрэгслүүдээс гадна биеийн дулаан алдагдахаас сэргийлсэн хөнжил, хөвөгч аврах хантааз зэрэг хэрэглэгдэнэ.

Нэмэлт мэдээллийг ИКАО Док 9137 - Нисэх буудлын ашиглалтын заавар Хэсэг7, Нисэх буудлын ОБ-ын төлөвлөлт, Хавсралт 6-д байгаа болно.

## **А.4 Онцгой байдлын аюулгүй байдал**

Онцгой байдлын аюулгүй байдлын үйл ажиллагаа нь *Аюулгүй Байдлын Үндэсний Хөтөлбөр, Аэродромын аюулгүй байдлын хөтөлбөр, Агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр* зэрэг баримт бичгүүдтэй уялдсан байна. Нисэх буудлын аюулгүй байдлын асуудалтай холбоотой сургалтууд нь эдгээр онцгой байдлын горимуудын үйл ажиллагаатай нийцсэн байна.

### **А.4.1 Хорлон сүйтгэх ажиллагаа**

Хорлон сүйтгэх ажиллагааны энэхүү горим нь агаарын хөлгийн эсхүл агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болохуйц навигацийн тоноглолуудын эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа гэж сэжиглэгдсэн эсхүл тогтоогдсон тохиолдол юм. Авах арга хэмжээнд дараах голлох чиглэлүүд орно.

- Агаарын хөлгийн болон бүхээгийн ажилтнууд, зорчигчдын аюулгүй байдлыг баталгаажуулах.
- Хорлон сүйтгэх ажиллагааны цаашдын оролдлого эсхүл нотолгоо, баримтыг шалгах.
- Хорлон сүйтгэх дараагийн ажиллагаанд тавих анхаарлыг илүү өндөр түвшинд хүргэх.
- Хорлон сүйтгэх ажиллагааны эх үүсвэрүүдийг олоход чиглэсэн нөхцөл байдлын талаарх мөрдөлөгийн ажиллагаа



#### **А.4.2 Хууль бус эзэмшилт /барьцаалалт/**

Онцгой байдлын энэхүү горимд агаарын хөлгийг булаах, өөрийн болгох үйлдэл эсхүл, хүн болон хүмүүс нь бусад хүчний эрхэнд орох, өөрсдийн зорилгыг биелүүлэхэд дэмжлэг болгох үүднээс заналхийлэл үзүүлэх зэрэг орно. Үүний эсрэг хариу үйлдлийг тусгай хүчин үзүүлэх, барьцаалах ажиллагаа нь даамжирсан эсэхээс шалтгаалаад аврах ажиллагааг удирдах байгууллага нь өөрчлөгдөнө.

Агаарын тээвэрлэгчийн авах арга хэмжээнд бусад агаарын хөлөг, эд хөрөнгө эсхүл хүмүүст учирч болох эрсдлийг бууруулах үүднээс тусгаарлах зогсоолтой байх шаардлага тавигдсан. Энэхүү талбай нь бусад барилга байгууламж, нислэгийн зам, нислэгийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжгүйгээр буюу хамгийн багадаа 100м зайд тусгаарлагдсан байна. Мөн тусгаарлах зогсоолыг үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гэрэлтүүлгийн хэрэгслээр тоногдсон байх эсхүл зөөврийн гэрэлтүүлгийн хэрэгслийг 30 минутын дотор суурилуулсан байна.

#### **А.4.3 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх /агаарын хөлөг/**

Онцгой байдлын энэхүү горим нь албан болон албан бусаар, эсхүл, бичгээр болон амаар агаарын хөлөг, агаарын тээвэрлэгч, эсхүл, зорчигчдын эсрэг тэсрэх бөмбөгөөр заналхийлэх агшин юм. Онцгой байдлын арга хэмжээ авах эхний шатанд энэ нь заль мэх эсэх эсхүл онцгой байдлын ажиллагааг идэвхижүүлэх шаардлагатай эсэхийг тогтоохын тулд боломжит байг тогтоох заналхийллийн үнэлгээний аргачлалыг ашиглах нь түгээмэл байдаг. Онцгой байдлын нөхцлийг удирдах байгууллагын ажиллагаа, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ, эсхүл, агаарын тээвэрлэгч байгууллагын онцгой байдлын нөхцлийг ямар нэгэн шатанд идэвхижүүлэх хүсэлтэнд саад болох ёсгүй.

ИНЕГ нь заналхийллийн зохицуулалтын ажиллагаа шаардлагатай болсон нөхцөлд 3 онцгой болон тусгай нөхцлүүдийг тогтоосон. Эдгээрийг дараах үед хэрэглэгдэнэ. Үүнд:

- (а) Агаарын хөлгийн хаалга хаалттай үед газарт болон агаарт заналхийлсэн
- (б) Агаарын хөлгийн хаалга нээлттэй үед газарт заналхийлсэн
- (в) Нисэхийн байгууламжуудад заналхийлсэн гэх мэт.

Дээрхи 3 тусгай нөхцөл бүрт гүйцэтгэх үүрэг, хариуцлагын өөрчлөлт нь өөр өөр хандлагатай байдаг. Заналхийллийг хүлээн авах ажиллагаа нь *Аюулгүй Байдлын Үндэсний Хөтөлбөр* болон холбогдох тусгай арга хэмжээний гарын авлага нь *Нисэхийн Аюулгүй Байдлын Ноцтой Мэдээллүүд*-д заагдсан болно.

#### **А.4.4 Эзэнгүй ачаа**

Эзэнгүй ачаанд шошготой болон шошгогүй цүнх эсхүл бусад зүйлс зэрэг дараах тохиолдол орно. Үүнд:

- Тухайн бүсэд байрлах зөвшөөрөлгүй байх
- Хүн болон эд хөрөнгөнд эвдрэл, гэмтэл учруулж болох боломжтой гэж тооцогдсон
- Харагдац болон байршил аль аль нь сэжигтэй гэж үзсэн гэх мэт.

Нисэх буудлын дотоодын холбогдох алба нь үзлэгийн арга хэмжээ авагдах үед зохих баталгаажуулалтын арга хэмжээг авна. Нисэхийн аюулгүй байдлын алба ачаа нь эрсдэл мөн эсэхийг тогтоохоор тэсрэх бөмбөг илрүүлэх төхөөрөмж, нохой, цацраг илрүүлэгч зөөврийн хэрэгсэл зэргийг ашиглана. ОБ-ын горим нь ерөнхийдөө ачааны эзэн олдохгүй эсхүл ачаагаа авахгүй буюу 5-10 минутын турш байсаар байвал

аюулгүйн үзлэгийн дараа онцгой байдал зарлах эсэхийг шийднэ. Хариу арга хэмжээ нь эзэнгүй ачааг аюулгүй гэж тогтоох хүртэл танхимаас зорчигчдыг гаргах явдал юм.

#### **A.4.5 Сэжигтэй зүйл**

Сэжигтэй зүйл гэдэг нь аюулгүй үзлэгийн төхөөрөмжөөр тэсрэх зүйлс байгаа нь илэрсэн ачааны зарим хэсэг, эсхүл, ачаа дамжуулах систем дэх баглаа, боодолтой зүйл болон ачааны эзнийг үзлэгт хамруулах боломжгүй, эсхүл, тодорхой бус зүйлийг хэлнэ.

Онцгой байдлын энэхүү горим нь нисэх буудлын аюулгүйн үзлэгийн эцсийн шат хүртэл идэвхитэй байх мөн сэжиг бүхий зүйл нь аюулгүй гэдэг нь батлагдах хүртэл үргэлжилнэ.

Үүнтэй төстэй ажиллагаа нь бас ачаа тээшний терминалын хяналтын дэлгэцийн үзлэгээр ачаа нь сэжигтэй гэж тогтоогдсон мөн ачааг таних холбогдох үйл ажиллагааны явцад мөрдөгдөх боломжтой.

Онцгой байдлын энэ горим нь зөвхөн хяналтын дэлгэц бүхий ачаа тээш болон ачаа дамжуулах систем дээр тэсрэх бодис илрүүлэх төхөөрөмж суурилагдсан нисэх буудалд ашиглагдах боломжтой.

#### **A.4.6 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх /барилга байгууламж/**

Онцгой байдлын энэхүү горим албан болон албан бусаар, эсхүл, бичгээр болон амаар барилга байгууламжийн дотор ,эсхүл, ойр орчимд суурилуулагдаж, доторхи хүмүүст аюул тулгарсан, эсхүл, бусад хүмүүст шууд биш аюул учруулахаар заналхийлэх агшин юм.

Зарим аэродромын үйл ажиллагаа эрхлэгч агаарын хөлөгт ашиглагддаг заналхийллийг үнэлэх аргачлалыг барилга, байгууламжид заналхийлэл учирсан эсэх нь тодорхой болон тодорхой бус гэдгийг тогтоохын тулд хэрэглэдэг.

Энэ нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулах томоохон нөлөөллийг багасгах арга хэмжээг тогтооход туслах боломжтой.

ИНЕГ нь заналхийллийн зохицуулалтын ажиллагаа шаардлагатай болсон нөхцөлд 3 онцгой болон тусгай нөхцөлүүдийг тогтоосон. Эдгээр нь дараах нөхцөлүүдэд хэрэглэгдэнэ. Үүнд:

- Агаарын хөлгийн хаалга хаалттай үед газарт болон агаарт заналхийлсэн
- Агаарын хөлгийн хаалга нээлттэй үед газарт заналхийлсэн
- Нисэхийн байгууламжуудад заналхийлсэн гэх мэт.

Дээрхи 3 тусгай нөхцөлд бүрт гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг өөрчлөлт нь өөр өөр хандлагатай байдаг. Заналхийллийг хүлээн авах ажиллагаа нь *Аюулгүй Байдлын Үндэсний Хөтөлбөр*-д заагдсан болно.

#### **A.4.7 Нийтийг хамарсан үймээн самуун**

Аэродром болон нисэх буудал дээр нийтийг хамарсан үймээн самуун үүссэн үед онцгой байдлын энэхүү горимыг хэрэглэнэ. Нийтийн үймээн самуун гэдэг нь бүлэг хүмүүсийн нэгдэл аэродромын үйл ажиллагааг зориудаар тасалдуулахаар тухайн талбар дээр цугларах үзэгдэл эсхүл эд хөрөнгийг сүйтгэх үйл ажилагааг хэлнэ. Жишээ нь нисэх буудлын түрээслэгчдийн эсрэг довтолох, терминалын барилга руу явсан замыг хаах, эсхүл, жагсагчид нь агаарын хөлгийн хөдөлгөөний бүсэд нэвтэрч нислэгийн үйл ажиллагааг тасалдуулах гэх мэт.

## **A.5 ОБ-ын бусад горимууд**

### **A.5.1 Байгалийн гамшиг**

Аэродромууд нь өөрийн бүсэд буй аюулыг үнэлэхэд туслах үүднээс өөрийн авран хамгаалах багуудтай ойр ажиллах шаардлагатай. Үндэсний авран хамгаалах нэгжээр нэрлэгдсэн эдгээр аэродромууд нь мөн энэхүү журамд ороогүй бусад эрсдэлүүдийг Иргэний Хамгаалалтын Үндэсний Төлөвлөгөөний шаардлагын дагуу биелүүлэх үүрэгтэй.

Газар хөдлөлт, салхи шуурга, үер, галт уулын дэлбэрэлт зэрэг байгалийн гамшгууд, эсхүл, цунами анхааруулга зэрэг нь онцгой байдлын иргэний хамгаалалтын асуудалд хамаарах бөгөөд аэродромын тусгай арга хэмжээний журам нь тухайн гамшгийн тохиолдол бүрт, эсхүл, хосолсон байдлаар боловсруулагдсан байна.

Газар хөдлөлт, гал түймэр, хүчтэй шуурга зэрэг нь тохиолдох магадлал өндөр тул эдгээрт илүү анхаарах шаардлагатай. Онцгой байдлын эдгээр горим нь хүний амь нас болон агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхөөр бол зарлагдах ёстой. Газар хөдлөлтийн нөлөөллөөр терминалын барилга, шатахууны сав, харааны болон радио навигацийн тоноглолууд, ХБЗ-ийн хучилттай гадаргуу зэрэг нь эвдрэх магадлалтай.

Аэродромын эдгээр байгууламжууд нь онцгой байдлын тохиолдол бүрийн дараа тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, эвдрэл гэмтэл, нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх зэргийг шалгах ёстой.

Зөвхөн нисэх буудлын албадууд онцгой байдлын нөхцөлд шилжих ёстой бөгөөд тэгсэн үед нисэх буудлын ажилтнууд нь агаарын хөлөг болон зорчигчдын аюулгүй ажиллагааны түвшин буурахгүй гэдгийг баталгаажуулах зорилгоор тоног төхөөрөмж болон үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн үнэлгээ өгнө.

Үерийн нөлөөгөөр талбай дээрх зорчигчид болон ажилтнуудын аюулгүй байдал мөн агаарын хөлөг болон газар дээрх навигацийн тоног төхөөрөмжүүдэд аюул учруулж болох хүчтэй салхи, бороо ордог.

Энэ тохиолдолд ерөнхийдөө эрсдэлийн хэмжээг бууруулах талаар арга хэмжээ авахыг зөвлөдөг. Үүнтэй холбоотой онцгой байдлын горим нь заагдсан хэмжээнээс илүү гарсан, аюулгүй ажиллагааны нөхцөл алдагдсан үед зарлагдана. Хүн бэртээгүй, эд хөрөнгөд томоохон эвдрэл тохиолдоогүй бол зөвхөн нисэх буудлын албадуудад энэ горимыг мэдээлнэ.

### **A.5.2 Объектийн буюу газар дээрх гал**

Энэхүү онцгой байдлын горим нь агаарын хөлгөөс бусад аэродромын байгууламжид гал гарсан үед зарлагдана.

### **A.5.3 Аюултай бодис**

Онцгой байдлын энэхүү горим нь аэродром дээр аюултай бодис асгарах үед зарлагдана. Аюултай бодис агуулсан хайрцаг нь талст хэлбэр бүхий аюултай ачаа гэсэн шошготой байна.

Аюултай бодисын олон тохиолдол нь ажилтнуудад тусгай анхааруулга өгч байхыг шаарддаг.

Шатахуун асгарах тохиолдол нь их байдаг бөгөөд энэхүү асуудал нь ОБЖ-д байгаа эсэхэд анхаарал хандуулах ёстой. Хэрэв байгаа бол хир хэмжээний шатахуун асгарсан нөхцөлд онцгой байдлын горимыг зарлах ёстойг тогтоосон байна.

Хэрэв асгарсан шатахууны хэмжээ нь онцгой байдлын арга хэмжээ авах түвшнийг нэмэгдүүлж байгаа бол энэ нь “Аэродромын осол”-ын горимын нэг нөхцөл болдог.

#### **А.5.4 Эмнэлгийн онцгой байдал**

Нисэх буудалд эмнэлгийн онцгой байдлын нөхцөл ихэвчлэн тохиолддог. Хүмүүст ихэвчлэн зүрхний шигдээс, зогсох, унах, амьсгалын хүндрэлүүд, нислэгийн үед дотор муухайрах гэх мэт хүндрэл тохиолддог.

Энэ үед орон нутгийн эмнэлгийн тусламж, эсхүл, эмч шаардагдана. Тэдгээрийг ирэх хүртэл нисэх буудлын ажилтнууд шаардлагатай арга хэмжээ авдаг.

ОБЖ нь энэхүү төрлийн тохиолдлуудад ихэнхидээ идэвхиждэггүй. Гэсэн ч эмнэлгийн онцгой байдлын үед шаардагдах арга хэмжээг авсан байх ёстой бөгөөд нилээд хүн гэмтэж бэртсэн тохиолдолд нисэх буудлын ажилтан арга хэмжээ авах боломжгүй юм.

Агаарын хөлгийн хүчтэй сэгсрэлтээс болж зорчигчид гэмтэх, бие муудах зэрэг эрүүл мэндийн асуудал ихээр үүснэ.

Эмнэлгийн онцгой байдлын нөхцөлд зорчигчдод хордлого өвчний шинж тэмдэг илэрсэн үед онцгой анхаарал халамж шаардлагатай байдаг. Халуурах /38° -аас дээш хэм хүртэл/, ойрхон бөөлжих, суулгах, эсхүл, биеийн арьсан дээр тууралт гарах зэрэг нь өвчний шинж тэмдэгт орно.

Эдгээр зорчигчдод хөл хорио тогтоох зэрэг онцгой арга хэмжээ авах шаардлагатай болдог.

Хөл хорио тогтоох нь бие тавгүйрсэн зорчигчийн өвчний шалтгааныг тогтоотол үргэлжлэх магадлалтай бөгөөд олон зорчигчийг хамарсан хоолны хордлого байх эсэхийг мөн нягтална.

#### **А.5.5 Нисэх буудалд гарсан зөрчил**

Онцгой байдлын энэхүү горимд нисэх буудлын гаднах байгууллагуудаас тусламж авах онцын шаардлагагүй тохиолдлууд хамаарна.

Нисэх буудлын харъяа албадуудад мэдээлэх боломжтой бөгөөд шаардлагатай авах арга хэмжээг авах боломжтой тээврийн хэрэслийн осол, шатахуун асгаралт, зарим бага зэргийн эмнэлгийн онцгой байдал зэрэг нөхцөлүүд нь үүнд хамаарна.

### **А.6 Дэмжих төлөвлөгөө**

#### **А.6.1 Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө**

Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь тусгайлан зарлагдсан ОБ-ын нөхцлүүдийн дагуу хэрэгждэг. Жишээ нь аюулгүй байдлын зөрчлүүд, барилга байгууламжийн гал, аюултай материал асгарах гэх мэт. Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь ОБЖ-ын нэг хэсэг байх боломжтой, эсхүл, ОБЖ-д заагдсан тусдаа баримт бичиг байж болно.

#### **А.6.2 Тусламж үзүүлэх журам**

Онцгой байдлын үед авах арга хэмжээнд, эсхүл, сэргээн засах үе шатанд тусламж үзүүлэх, олон нийттэй харьцах зохих байгууллагуудын туслалцааг авах шаардлага үүсдэг. Эдгээр нь дараах тохиолдлуудад хэрэглэгдэнэ. Үүнд:

Угтан авагчид болон үдэгчидтэй харилцах.

Яаралтай тусламж шаардлагагүй амьд үлдэгсдийг анхаарах.

Ажилтнуудад шаардлагатай тусламж үзүүлэх, ослын дараах мэдээллүүдийг илтгэх

Ослын талбар руу эргэж нэвтрэхийг хүссэн амьд үлдэгсэд болон хамаатан саднуудтай харилцах.

Аэродромын онцгой байдлыг Төлөвлөх хороо ОБЖ-ын арга хэмжээнүүдэд дэмжлэг үзүүлэх олон нийтийн тусламж үзүүлэх журмыг боловсруулах асуудлыг анхаарах шаардлагатай. Нийтийн тусламж үзүүлэх журам нь ОБЖ-ын нэг хэсэг байж болох, эсхүл, ОБЖ-д заагдсан тусдаа баримт бичиг байж болно.

Ихэнх агаарын тээвэрлэгчид нь нийтийн тусламж үзүүлэх журамтай байхаар заагдсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй тусгайлан сургагдсан ажилтнуудтай байх шаардлагатай. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон агаарын тээвэрлэгчид нь бие биенийхээ нийтийн туслалцаа үзүүлэх журмын талаар бүрэн мэдлэгтэй байна.

Хохирогсдод тусламж үзүүлэх, Аврах анги, Улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагууд нь нийтийн туслалцаа үзүүлэхэд сургагдсан ажилтнуудтай байдаг.

#### *Угтан авагчид болон үдэгчдэд халамж үзүүлэх*

Онцгой байдлын арга хэмжээ авагдах үед осолд нэрвэгдсэн зорчигчдын талаарх мэдээллийг олох ажилд /таних, тогтоох болон нийлүүлэх ажиллагаанд/ цагдаагийн газарт туслах, угтагчид болон үдэгчдэд анхаарал халамж үзүүлэх зэрэг ажилд нэмэлт хүч шаардлагатай болдог.

Хүчтэй лидерүүдийг татан оролцуулах болон англи, Монгол хэл мэддэггүй зорчигчид олон байгааг тооцон орчуулагч нарыг оролцуулах асуудлыг анхаарах ёстой.

Нэмэлт мэдээллүүд энэхүү зөвлөмжийн цувралын Хавсралт Е-д орсон болно.

#### *Амьд үлдэгсдийг халамжлах*

Яаралтай тусламж авах шаардлагагүй амьд үлдэгсдэд ямар нэгэн тусламж үзүүлэх шаардлага бий болдог. Үүнд таних, эд зүйлсийг олох зорилгоор хувийн мэдээллүүдийг тогтоох, гэр бүл, хамаатан садантай нь холбогдох мэдээллүүдийг тогтоох зэрэг ажил хамаарна.

#### *Хариу үйлдэл үзүүлэгчид болон албан хаагчдыг халамжлах*

Онцгой байдлын нөхцлийн дараа нөхөн сэргээх шатанд олон нийтийн тусламж шаардлагатай байдаг. Хариу үйлдэл үзүүлэгчид болон албан хаагчид нь аэродромын осол зөрчлийн үед, ялангуяа, агаарын хөлгийн ослын үед мөн бэртэж гэмтэх магадлалтай.

Ослын талбайд ажиллаж буй бүх байгууллагууд нь тасралтгүй туслалцаа үзүүлэх болон ноцтой ослын дарамт, хямралыг арилгах мэргэжлийн туслалцаа авахад анхаарах шаардлагатай. Хохирогсдыг анхаарах, эсхүл, энэ тохиолдолд салбарын сэтгэл зүйч нар ихэвчлэн шаардлагатай болдог.

*Ослын талбар руу эргэж нэвтэрч буй амьд үлдэгсэд болон хамаатан саднуудыг халамжлах.*

Олон нийтийн тусламж үзүүлэх журам нь ослын талбар руу эргэж нэвтрэхийг хүссэн амьд үлдэгсэд болон хамаатан саднуудын боломжыг анхаарсан байна.

### **А.6.3 Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө**

Агаарын хөлөг нь хөдөлгөөний бүсэд осолд орох, хөөрч буух зурвас болон явгалах замаас гарах, шингэний даралт унах, дугуй хагарах зэрэг техникийн доголдол, гэмтэл үүссэнээс болоод хөдлөх чадваргүй болох боломжтой. Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө нь хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг тодорхой хугацаанд ямар нэгэн цаашдын эвдрэл гэмтэлгүйгээр буюу тухайн бүсийг нислэгийн үйл ажиллагаанд аль болох түргэн оруулахын тулд шилжүүлэх ажлыг баталгаажуулсан байна. Агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах нь эцэстээ агаарын тээвэрлэгчийн хариуцлага байдаг. Агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулахад оролцогч бүх байгууллагуудын

зохицуулалт нь тусдаа журам болон боловсруулагдсан нөхцөлд энэхүү ажиллагааны үр дүн нь илүү сайжрах талтай. Журам нь ОБЖ-ын нэг бүрдэл байх эсхүл ОБЖ-д заагдсан тусдаа баримт бичиг байж болно.

Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө нь ОБЖ шиг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах үүднээс оролцогч байгууллагуудын үүрэг болон хариуцлагыг багтаасан, тэрчлэн энэхүү ажиллагаа эхлүүлэх холбооны системийг бүрдүүлсэн байна.

Дараах байгууллагууд үүнд хамрагдах боломжтой. Үүнд:

- Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч
- Агаарын тээвэрлэгч
- Агаарын хөлгийн засварын байгууллага
- Нисэх буудлын галын алба эсхүл онцгой байдлын галын алба
- Нисэхийн шатахууны алба
- Аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагууд
- Тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүд, эсхүл, бусад үйлчилгээ үзүүлэгчид

Үүн дээр нэмээд орон нутгийн нөөцийн жагсаалт буюу орон нутгийн нэмэлт хүчнүүд, агаарын хөлгийг шилжүүлэх тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүдийн байршил, холбогдох ажилтнуудтай холбоо барих тогтмол шинэчлэгдэж байдаг дугаар зэргийн хамт төлөвлөгөөнд орсон байна. Тоног төхөөрөмжүүд байнгын бэлэн байдалд буй эсэх болон аэродром дээр нислэг үйлдэж буй агаарын хөлөгт таарах зэрэгт хяналт тавих, баталгаажуулах зорилгоор төлөвлөгөөг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол хянаж, шинэчилж байх шаардлагатай.

Шаардлагатай нөөцүүдийн жишээ:

- Агаарын хөлгийг чирэх болон өргөх төхөөрөмжүүдийн мэргэжилтнүүд
- Агаарын хөлгийн шатахууныг соруулж авах төхөөрөмж
- Өргөх болон татах цамхаг эсхүл хэрэгсэл

Агаарын хөлгийн дугуй болон тоног төхөөрөмж явахад зориулсан замыг ухах төхөөрөмжүүд

- Ажлын тавцан, явах замыг сайжруулахад хэрэглэх хайрга, төмөр болон модон эдлэлүүд
- Агаарын хөлгийн эд анги, материалуудыг зөөх хүнд даацын тээврийн хэрэгсэл болон чиргүүлүүд
- Усан дахь агаарын хөлгийг аврах болон хөвүүлэх мэргэжилтнүүд
- Нүүлгэн шилжүүлэх ажиллагаа харанхуйд явагдах үед хэрэглэх гэрэлтүүлгийн төхөөрөмжүүд

Шаардлагатай материал болон тоног төхөөрөмжийн дотоодын нөөцүүд:

- Талбай дээрх агаарын тээвэрлэгч
- Талбай дээрх засварын үйлчилгээ үзүүлэгчид
- Гэрээт компаниуд
- Өргөгч цамхагийн оператор
- Хүнд механизмын оператор
- Аврах мэргэжилтнүүд
- Хайрга болон гуалин банз зэрэг модон бүтээгдэхүүнүүд

Төлөвлөгөөг батлагдсан тохиолдолд сэргээх ажиллагааны удирдлагын төлөвлөлтөнд туслах зорилгоор тоног төхөөрөмжийг талбай дээр бэлэн байлгахад зарцуулагдах хугацааг заасан байна.

#### **A.6.4 Хэвлэл мэдээллийн удирдлагын төлөвлөгөө**

Хэвлэл мэдээлэл болон олон нийтийн анхаарлыг аэродромын онцгой байдлын нөхцлүүд, ялангуяа, агаарын хөлгийн осол маш ихээр татдаг. Мөн угтагчид болон үдэгчид онцгой байдлын нөхцлийн талаарх мэдээллийг шаарддаг. Энэ төрлийн мэдээллүүд нь тусгай хянах аргачлалаар сайтар зохицуулагдсан байна.

Онцгой байдлын дотоод нөхцөл, хэтийн төлөвийг тогтоох боломжтой ямар ч ажилтанд хэвлэл мэдээлэл хандах боломжтой. Нисэх буудлууд нь өөрсдийн холбогдох хэвлэл мэдээллийн багийг тодорхой, бодит мэдээллээр хангаснаар олон нийт болон бусад гадны хэвлэл мэдээллийн байгууллагуудыг цаг хугацааны хувьд шуурхай, нарийвчилсан мэдээлэл өгөх боломжийг олгодог.

Иймээс ОБЖ-д ямар нэгэн хязгаарлалтгүй, мэдээллийн авах хүсэлтүүдийг хэрхэн зохицуулах, тарааж буй мэдээллүүдийг баримтжуулах, холбооны сувгуудыг сайжруулах, мэдээлэл түгээх байр болон мэдээлэгч, хэвлэлийн төлөөлөгчийг томилох зэргийг агуулсан холбогдох хэвлэл мэдээллийн төлөвлөгөөг оруулсан байхаар заагдсан. Хэвлэл мэдээллийн төлөвлөгөө нь ОБЖ-ын нэг хэсэг эсхүл тусдаа баримт бичиг байж болно.

Онцгой байдлын арга хэмжээ авах хугацааны туршид онцгой байдлын нөхцлийг удирдах туршлагаар агаарын тээвэрлэгч болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгч зэрэг бусад байгууллагуудын тусламжтайгаар онцгой байдлын алба хэвлэл мэдээллийн асуудлыг хариуцна. ОБЖ-ын хавсралт Хэвлэл мэдээллийн төлөвлөгөөнд дурьдагдсан эрх бүхий/зөвшөөрөгдсөн төлөөлөгчид мэдээлэл авах бүх хүсэлтүүд очиж буй эсэхийг баталгаажуулна.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг тодорхой, бодит, шуурхай мэдээллээр хангаж ажиллах нь чухал юм. Маш олон агаарын тээвэрлэгчидэд агаарын хөлгийн осол гарсан газар байршуулах тоног төхөөрөмж хэрэгсэлүүд байх шаардлагатай бөгөөд Цагдаагийн газар ч бас зарим шаардлагатай хэрэгслүүдтэй байна. Энэ тогтолцоо нь онцгой байдлын үед холбооны сүлжээг чөлөөтэй ашиглах боломжтой олгохоос гадна осолтой холбоотой бүх мэдээллийг зохицуулах боломж бүрдүүлдэг.

## **Хавсралт В - Холбооны хэрэгсэл болон зохицуулалт**

### **В.1 Холбооны хэрэгсэл**

Холбооны хэрэгсэл нь аэродромын онцгой байдлын үе дэх хамгийн чухал зүйл юм. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ОБЖ-д заагдсанаар онцгой байдлын үед шуурхай авах арга хэмжээнүүдийг баталгаажуулсан байх үүрэгтэй. Онцгой байдлын ажиллагаанд оролцох үүрэг бүхий байгууллагууд, ажилтнуудыг шаардлагатай онцгой байдлын горимд яаралтай шилжүүлэхэд түгшүүрийн дуудлагыг маш хурдан өгөх нь чухал. Онцгой байдлын арга хэмжээ авах үүрэгтэй байгууллага, ажилтнуудад дуудлага өгөх дарааллыг ОБЖ-д тодорхой заасан байна. Онцгой байдлын нөхцлийг цуцлах болон үүрэг бүхий байгууллагуудыг бэлэн байдлын горимд шилжүүлэх дараалал, үйл ажиллагааг мөн оруулсан байна.

Онцгой байдлын төрөл тус бүрээр анхны ослын дуудлага өгөх үүрэг бүхий ажилтныг тодорхой болгосон байна. Томоохон аэродромуудад нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв, аврах, гал унтраах алба, аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон харьяа алба салбарууд байх нь түгээмэл байдаг. Аюулгүй байдалтай холбоотой онцгой байдлын үед Цагдаагийн газар болон ИНЕГ байж болох юм.

24 цагийн үйл ажиллагаа явуулдаггүй жижиг нисэх буудлуудад Цагдаагийн газар болон Гал унтраах алба онцгой байдлын түгшүүрийг зарлах болон холбогдох ажиллагааг эхлүүлнэ. Онцгой байдлын түгшүүрийн систем ажиллагаатай эсэх, ОБЖ-д заагдсан утасны дугаарууд зөв эсэхийг тогтмол шалгаж баталгаажуулах шаардлагатай бөгөөд алдаа дутагдлуудыг илрүүлж холбогдох арга хэмжээг авна. Хуваарьт бус шалгалтын ажиллагаа нь өөр өөр операторуудаар, өдрийн өөр цагуудад шалгах боломжийг олгодог. Аэродромын онцгой байдлын түгшүүр зарлах нь маш олон аргаар хийгдэх боломжтой байдаг. Дараах арга нь ихэвчлэн хэрэглэгддэг болно.

## **В.2 Холбооны систем**

### **В.2.1 Каскадын систем /төлбөргүй дуудлага/**

Каскадын системээр онцгой байдлын түгшүүрийг идэвхижүүлэгчээс нэг удаагийн дуудлага бүлэг хүмүүс рүү хийгдэх бөгөөд онцгой байдлын түгшүүр зарлагдана. Дуудлага хүлээн авагч нь ирсэн мэдээллийг дуудлага өгөгчид дахин уншиж өгөх бөгөөд ингэснээр мэдээллийг хүлээн авсан болон зөв ойлгосон эсэхийг баталгаажуулдаг. Дуудлага хүлээн авсан хүмүүс нь онцгой байдлын үед өөрсдийн үүргийн дагуу доод түвшний хүмүүс рүү түгшүүрийн дуудлагыг дамжуулна. Энэ мэтчилэнгээр дуудлага Каскад буюу доош чиглэсэн дэс дараалалтайгаар жагсаалтанд байгаа бүх байгууллага болон ажилтнуудад бүрэн мэдээлэгдэх хүртэл үргэлжилнэ.

Салбарласан дуудлаганд /каскад/байгаа байгууллагууд болон ажилтнууд нь онцгой байдлын үед авах хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээнд онцолсон байдлаар тодорхой түвшинд ангилагдсан байна. Нисэх буудлын аврах, гал унтраах алба, онцгой байдлын галын алба, Цагдаагийн газар, түргэн тусламжийн үйлчилгээ зэрэг онцгой байдлын албадууд нь каскадын системийн хамгийн дээд талд ямагт байна. Жагсаалтанд орсон байгууллага болон ажилтнуудын авах арга хэмжээ нь үүссэн онцгой байдлын төрлөөс шалгаалдаг. Онцгой байдлын зарим нөхцөлд бүх байгууллага оролцох албагүй бөгөөд харин зарим төрөлд тусгай мэргэжилтнүүд нэмэлт хэрэг болох талтай.

ИНД 139-ийн дагуу ОБЖ-д заагдсан байгууллага болон ажилтнуудын холбогдох утасны дугаар, нэрс нь шинэчлэгдэн засварлагдаж байх шаардлагатай.

Каскадын систем нь мөн зарим сул талуудтай. Онцгой байдлын үед ажиллах ёстой бүх байгууллага ажилтнуудад шаардлагатай мэдээлэл хүргэхийн тулд нэлээд хугацаа шаардагддаг бөгөөд, ялангуяа, дуудлага хүлээн авагч дуудлага өгөгчөөс ирсэн мэдээллийг үнэн зөв сонссон, ойлгосон эсэхийг нягтлахын тулд эргэж залгах, дахин унших, нягтлах ажилд маш их хугацаа зарцуулдаг.

Аэродром дээр гарсан агаарын хөлгийн осол зэрэг маш ноцтой онцгой байдлын нөхцлийн үед утсан холбооны сүлжээ хэт их ачааллаас болж мэдээллийг дамжуулах боломжгүй болох эрсдэлтэй.

Аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь холбооны үндсэн систем ажилгүй болсон, эсхүл, саатсан үед мэдээлэл дамжуулах нөөц хувилбаруудыг тогтоосон байх шаардлагатай бөгөөд энэ талаар ОБЖ-д дурьдсан байна.

### **В.2.3 Онцгой байдлын түгшүүрийн автоматжуулсан систем**

Онцгой байдлын автоматжуулсан түгшүүрийн систем нь (АТС) зориулалтын шугам, үүрэн холбоо, өгөгдөл/радио дамжуулах, урьдчилан бэлтгэгдсэн мэдээллүүдийг олон тооны байгууллагад нэгэн зэрэг илгээх зэрэг маш олон төрлийн дамжуулалтыг хийх чадвартай.



Эхлэн боловсруулагч нь мэдээллийн бичиглэл ,эсхүл, хуулбарыг автоматжуулсан түгшүүрийн систем рүү илгээдэг. Мэдээлэл АТС-рүү шилжмэгц системд холбогдсон бүх байгууллагууд руу автоматаар илгээгдэнэ.

Системийн төрлөөс шалтгаалж мэдээлэл хүлээн авагч нь компьютерийн дэлгэц дээр, цаасан хэвлэмэл байдлаар, гар утас, мессэж ,эсхүл, дуут шуудангаар хүлээн авдаг болно.

Бичигдсэн дуут шуудан нь мессэжийг хүлээн авсан даруйд хүлээн зөвшөөрөх хариу үйлдлийг шаарддаг. Илүү автоматжуулсан систем нь дэлгэцэн дээр мэдээлэл илгээгчийн хүлээн авсан, мэдээллийг хүлээн зөвшөөрсөн байдлыг үзүүлдэг.

АТС-ийн үндсэн давуу талууд нь:

Мэдээллийг олон байгууллагад нэгэн зэрэг илгээх, хариу илгээх нийт хугацааг багасгах, операторт шаардлагат өөр үүрэгт ажлуудаа гүйцэтгэх боломж олгодог.

- Бусад нэмэлт байгууллагууд, дуулага хүлээн авагчийг сүлжээнд нэмэх нь маш энгийн бөгөөд ялангуяа радио болон өгөгдөл болон зориулалтын бус шугам ашиглаж байгаа үед.
- Хэрэв АТС нь радио өгөгдөл дамжуулагч ашиглаж байгаа бол хобооны шугамын сүлжээний хэт ачаалал болон бусад асуудал нөлөөлөхгүй.
- Зурвас мэдээлэл нь мессэжийг бичиглэл хийх болон илгээсэн мэдээлэл нь эргэж уншиж батлагаажуулах хэрэгтэй бол илүү богино хугацааг шаарддаг.
- Мессэжийг оффос болон машинд гэх мэтчилэн маш олон байршлуудад хүлээн авах боломжтой.

АТС-ийн үндсэн сул талууд нь

- Суурилуулах зардал
- Хэрэв үүрэн утас ашиглаж байгаа бол томоохон онцгой байдлын үед сүлжээний хэт ачаалал бий болох талтай.

#### **В.2.4 ОБ-ын Түгшүүрийн системийн мэдээллийн маягт**

Хэрэв мэдээлэл нь мессеж хэлбэрээр автоматаар илгээгдээгүй тохиолдолд нарийвчилсан мэдээллүүдийг бичиж авах үүднээс хэрэглэх стандартын автоматжуулсан мэдээллийн системийн маягт нь байгууллагуудад тараагдсан байна. Энэ нь шаардлагатай бүх мэдээлэл өгөгдсөн болон холбогдох байгууллагад заагдсан шаардлагатай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлдэг.

Мэдээллийн шинж чанар нь онцгой байдлын төрлөөс хамаарч өөр хоорондоо адилгүй байх бөгөөд мэдээллийн маягт нь стандартчилагдсан байх нь чухал юм. Галын алба, түргэн тусламж зэрэг нь өөр өөр байршилтай олон тооны аэродромуудаас онцгой байдлын дуудлага хүлээн авах байгууллагуудын нэгдсэн холбооны төвийн шаардлагыг баталгаажуулсан байна.

Аль байгууллага нь эхэлж дуудлага хүлээн авахыг үл харгалзан дараагийн мэдээлэл дамжуулахаас өмнө аль дуудлага нь хийгдсэн бэ гэдгийг тогтоох нь чухал байдаг.

Агаарын хөлгийн ослын талаарх мэдээллийн бүтцэд мэдээллийг дараах байдлаар эрэмбэлнэ. Үүнд:

- Оршил - ослын бус үед хэрэглэх, холбоо болон дадлагын зориулалтаар гэх мэт.
- Онцгой байдлын үе шат - агаарын хөлгийн осол, сүйрэл, бүрэн хэмжээний онцгой байдал болон бэлэн байдлын горим
- Хөөрч буух зурвасны байрлал - ослын байрлал, эсхүл, агаарын хөлөг буулт үйлдэх хөөрч буух зурвас

- Агаарын хөлгийн төрөл
- Буух тооцоот цаг
- Ослын буулт үйлдэх шалтгаан, төлөв байдал
- Агаарын хөлгийн зорчигчид болон нисэх баг
- Үлдэгдэл шатахууны хэмжээ /мэдэгдсэн үед/
- Агаарын хөлөгт буй аюултай ачаа

Оршил, онцгой байдлын үе шат, дуудлагыг эргүүлж унших нь тусгай дөрвөлжинд тэмдэглэгдэх боломжтой. АТС-ийн мэдээллийн А загварыг Зураг 1 -ээр үзүүлэв.

Хэрэв шаардлагатай бүх мэдээлэл нь мэдэгдэх боломжгүй эсхүл мэдэгдсэн бол мэдээллийн хамгийн чухал хэсгийг зарласан байвал зохино. Дээр үзүүлсэн мэдээллийн бүтэц нь мэдээлэл бүрийн хамгийн чухалчилж үзсэн бүрдлүүд бөгөөд чухал бүрдлүүд нь дарааллын эхэнд байрлах шаардлагатай.

Өмнө нь мэдээлэгдээгүй бүрдэлүүд нь боломжтой болсон үед дутуу байсан мэдээллийг онцгой байдлын албадад дахин мэдээлнэ.

### *Байршил*

Аэродромын гадна үүсэн зөрчил, эсхүл, аэродром нь захын дүүрэгт байрласан тохиолдолд, хариу үйлдэл үзүүлэгчдэд онцгой байдлын үед ашиглах тухайн орчны байршлын торлосон зургийг тарааж мэдээллийн дагуу зааварлана. Энэ нь тэдгээрт тухайн байршилд очиход газарзүйн янз бүрийн саад тотгороос зайлсхийн хамгийн найдвартай замаар очих боломжийг бүрдүүлдэг.

Хотын төвд байрласан аэродромын хувьд хотын захын орчмын байршлын зураг, гудамжны нэр зэрэг мэдээлээр онцгой байдалд хариу үйлдэл үзүүлэх албадыг хангасан байна.

### *Агаарын хөлгийг таних*

Агаарын хөлгийг таних ажиллагаанд хэрэв тодорхой бол агаарын хөлгийн жингийн ангиллын мэдээллийг ашиглана. Гал унтраах алба нь агаарын хөлгийн төрөл, хэмжээнд тохирсон тооны галын машиныг явуулах боломжтой. Хэдийгээр галын алба нь агаарын хөлгийг хүнд, хөнгөн, цэргийн гэж ангилсан байдаг боловч өөр аргачлалаар тогтоох үед эдгээр мэдээлэл нь чухал бус байдаг.

Боломжтой бол агаарын тээвэрлэгчийн нэр, агаарын хөлгийн дуудлага зэргээр мэдээллийг хангасан байна. Авах арга хэмжээний зорилго нь маш яаралтай биш боловч онцгой байдлын албадуудын үйл ажиллагаанд үнэтэй дэмжлэг болдог.

**Зураг 1 - Онцгой байдлын мэдээллийн маягтын загварын жишээ**

**Онцгой байдлын мэдээллийн маягтын загвар**

.....Нисэх буудлын онцгой байдлын алба

Оршил	(Зөвхөн онцгой байдлын бус үед ашиглах)
<input type="checkbox"/>	Дадлага (Гурван удаа хэлэх)
<input type="checkbox"/>	Холбоо шалгах (Гурван удаа хэлэх)

Үе шат

<input type="checkbox"/>	Осол	Осол	Осол
<input type="checkbox"/>	Бүрэн ОБ	Бүрэн ОБ	Бүрэн ОБ
<input type="checkbox"/>	Бэлэн байдал	Бэлэн байдал	Бэлэн байдал

- а. Хөөрч буух зурвасны байрлал.....
- б. Агаарын хөлгийн төрөл.....
- в. Буух тооцоот цаг.....
- г. Ослын буулт хийх шалтгаан, төлөв байдал.....
- д. Агаарын хөлгийн зорчигчид болон нисэх баг.....
- е. Үлдэгдэл шатахууны хэмжээ.....
- ж. Агаарын хөлөгт буй аюултай ачаа.....

Эргэж унших	<input type="checkbox"/>
Хүлээн авсан цаг	

Илгээсэн:	Байгууллага	Цаг
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

Аэродром дээрх бусад осол

Гал, аюулгүй байдлын заналхийлэл, аюултай материал асгарах, эмнэлгийн зэрэг аэродром дээрх бусад ослын үед шаардлагатай холбогдох мэдээлэл нь

- Ослын байршил
- Ослын төлөв байдал

Аэродромын онцгой байдлын үед ажиллах байгууллагуудыг ОБЖ-ын мэдээлэл, эсхүл, тусгай үйл ажиллагаа, журмуудын талаарх мэдээллээр хангах нь чухал. Бүх байгууллагууд нь тэдгээрийн тоног төхөөрөмж, машин механизмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ОБЖ-д оруулаагүй байх, эсхүл, ослын талбар дээр гүйцэтгэх өөрсдийн үүргийг бүрэн мэдэхгүй байх магадлалтай. Үүнд ОБ-ын тэргүүлэх байгууллагууд болох цагдаагийн газар, гал унтраах алба, түргэн тусламж зэрэг хамгийн ойр байрлах нэгжүүдийн авах шаардлагатай арга хэмжээнүүд орно.

Онцгой байдлын үед хамгийн түрүүнд хариу үйлдэл үзүүлэх нисэх буудалд ойрхон байрлалтай байгууллагуудад зориулан тусгайлсан хэсгүүдийг аэродром дээр, эсхүл, терминалын гадна, магадгүй шуудангийн салбар зэрэг газруудад бий болгоно.

### **В.3 Жижиг аэродромуудыг анхаарах**

Жижиг болон алслагдсан аэродромууд нь (нислэгийн талбайг оролцуулан) онцгой байдлын үед арга хэмжээ авах ажилтангүй байж болох юм. Магадгүй аэродром мэдэхгүй болон түүний үйл ажиллагаатай танил биш хүмүүст найдах шаардлагатай болдог. Энэ нөхцөлд аэродромын нэр болон бодит байршлыг заасан, холбогдох шаардлагатай утасны дугаарыг хүний нэртэй нь хамт үзүүлсэн тэмдэгтийг сайтар харагдахуйц газар байрлалуулсан байна.

### **В.4 Гуравдагч аэродром руу мэдээлэл өгөх**

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх мэдээллээр хангах асуудлыг анхаарах бөгөөд хэрэв энэ нь агаарын тээврийн үйл ажиллагаа бол нислэг эхэлсэн болон очих аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдийг ослын талаархи мэдээллээр хангана. Ерөнхийдөө энэ нь агаарын тээвэрлэгчээр дамжуулагдах боловч тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээнээс мөн хамаарах тул аэродромын үйл ажиллагаа эрхлэгч мэдээллийг шаардлагатай хугацаанд бас мэдээлнэ.

Энэ нь гуравдагч аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдийн аэродром дээр угтагсад болон үдэгсэд, хамаатан садан, хэвлэл мэдээлэл зэрэгтэй холбогдох арга хэмжээ авах боломжийг олгоно. Жишээ нь: агаарын хөлөг хөөрөөд удаагүй байхад гарсан осол. Телевизийн нэвтрүүлгээр цацагдаж буй ослын талаарх өргөн хүрээний хэвлэл мэдээллийн дүрс бичлэгээс ослын эсрэг арга хэмжээг авна. Энэ арга хэмжээг мөн аэродром дээр хүлээж буй хамаатан саднууд нь телевизээр үзсэн. Тухайн аэродром дээрхи агаарын тээвэрлэгчийн ажилтнууд болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ямар ч бэлтгэлгүй байсны улмаас шаардлагатай арга хэмжээг зохих ёсоор авч чадаагүй. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ослын мэдээлэл дамжуулах талаар ослын үеийн стандарт, журамд оруулсан байна.

### **В.5 Зохицуулалт**

ОБЖ нь аэродромын онцгой байдлын үед байгууллага болон ажилтнуудын авах арга хэмжээг үр дүнтэйгээр зохион байгуулсан болохыг баталгаажуулна. Тусгай байгууллага болон ажилтнууд нь онцгой байдлын ямар ч нөхцөл, шатанд эсрэг авах арга хэмжээний чухал хэсгүүдийг бүрдүүлнэ.

ИКАО-ын Док 9137 - Нисэх буудлын үйлчилгээний гарын авлага Хэсэг 7, Бүлэг 3 болон 4, Нисэх буудлын ОБ-ын Төлөвлөлтийн баримт бичгүүд нь байгууллагуудын онцгой

байдлын явцад гүйцэтгэх үүрэг болон холбогдох албадуудыг дурьдсан болно. Байгууллагууд болон ажилтнуудын гүйцэтгэх үүргийг тодорхой болгож ОБЖ-д заасан байна.

Цагдаагийн газар болон Гал унтраах алба, Түргэн тусламж зэрэг тэргүүлэх байгууллагууд нь яаралтай авах арга хэмжээг ихэвчлэн удирдан явуулдаг. Халдварт өвчин зэрэг зарим нэгэн онцгой ажлыг тухайн дүүргийн Эрүүл мэндийн байгууллага удирдан явуулна.

### **В.5.1 Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС)**

Ослын үед байгууллага хоорондын ажиллагааг сайжруулах үүднээс онцгой байдлын албадууд нь Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС) нэртэй онцгой байдалд авах арга хэмжээний загварыг гаргасан. Энэхүү загвар нь тэдгээр байгууллагуудын онцгой байдлын үеийн хамтарсан ажиллагааг стандартчилсан болно. ЗУЗС нь онцгой байдлын үеийн удирдлага, хяналт, зохицуулалтын загвар юм.

Энэ нь ямар ч хэмжээний онцгой байдлын нөхцлийг удирдах болон оролцогч байгууллагуудын үүрэг, хариуцлага, зохицуулалтын дүрмийг тодорхойлдог.

ЗУЗС нь дараах зүйлүүд дээр үндэслэнэ. Үүнд:

- Удирдлагын нэр томъёо
- Байгууллагын бүтэц
- Нэгдсэн холбоо
- Ослын үеийн арга хэмжээний төлөвлөгөө (ОБЖ)
- Удирдлагын хир хэмжээ
- Онцгой байдлыг зохицуулах төв болон үйл ажиллагааны төв зэргийг оролцуулсан тоног төхөөрөмж байгууламжууд
- Нийт нөөц эх үүсвэрүүдийн удирдлага

ОБ-ын цар хүрээнээс хамаарч ЗУЗС нь үндсэн 4 хүчин зүйл дээр тулгуурлана. Үүнд:

- Хяналт - зөрчлийн удирдлага
- Төлөвлөлт болон шийдвэрлэлт - ослын мэдээллийг цуглуулах болон дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг төлөвлөх
- Үйл ажиллагаа - ослын нөхцөлд тохируулан байгууллагын нөөцийг чиглүүлэх
- Логистик - ослын нөхцөлд тохирсон хэрэгцээт байгууламж, тоног төхөөрөмж, материал, үйлчилгээний шаардлагууд

Ослыг хянах нь ослын хяналтын ажилтны үүрэг хариуцлага юм. Ослын хяналтын ажилтанд доорх шаардлагууд тавигдана.

- Удирдлага болон хяналтыг тогтоох
- Зөрчлийн удирдлагын цэгийг тогтоох
- Хүний амь болон эд хөрөнгийг хамгаалах
- Хүмүүс болон тоног төхөөрөмжийг хянах
- Хариу үйлдэл үзүүлэх байгууллагууд тооцоотой байх ОБ-ын үндсэн үүргийг биелүүлэхээс гадна нийтийн аюулгүй байдлыг хангах

- Онцгой байдлыг арилгах үйл ажиллагаа эхэлсэн үед гадны байгууллагууд болон онцгой байдлыг зохицуулах төвтэй харилцаа холбоотой ажиллах.

Дараах ажлууд нь маш чухал юм. Үүнд:

- Байгууллагуудын хооронд хэвтээ байдлаар ажилладаг болон тухайн нөхцөл байдалтай холбоотой ослын хяналт
- Байгууллагуудын хооронд босоо байдлаар үйл ажиллагаа явуулдаг удирдлагын шугамууд

Зөрчлийн талбарт зөвхөн 1 ослын хянагч байх боловч олон байгууллага оролцохын хирээр олон тооны удирдлагын шугам байдаг.

Зөрчил өсөхийн хирээр ослын удирдлагын цэг, онцгой байдлыг зохицуулах төв зэрэг байгууламжууд нь байгуулагдсан байна.

- Нөөц эх үүсвэрүүд ослын талбар, эсхүл аюулгүйн цэг руу очихоос өмнө нэг дор цугларах бүсийг Цугларах бүс гэнэ.
- Зөрчилд ойрхон байрлах, тодорхой аюулгүйн зайнд үйл ажилаагааны тусламж үзүүлэх боломж бүхий бүсийг Аюулгүйн цэг гэнэ.
- Ослын талбар нь байгууламжуудаас хол, нөөц эх үүсвэрүүдийг бэлтгэх, тарааж байршуулах бүсийг Цугларах бүс гэнэ.

### **В.5.2 Онцгой байдлыг зохицуулах төв (ОБЗТ)**

#### **ИНД 139.57 (б)5**

Олон улсын нисэх буудал нь Үнцгой байдлыг зохицуулах төвтэй (ОБЗТ) байхыг дүрэмд шаардсан байдаг.

ОБЗТ нь осол, зөрчлийн хяналтын ажилтнуудад туслах зорилготой аэродром дээрх суурин байгууламж юм. Хэдийгээр ноцтой ослыг мэдээлсэн үед аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн байгууламжууд нь бэлэн байх шаардлагатай ч томхон хэмжээний онцгой байдлын үед л энэхүү байгууламж нь идэвхиждэг.

Энэ нь онцгой байдлын дотоодын хяналтын ажилтны байрлалыг тодорхойлно. Дотоодын хяналтын ажилтны үйл ажиллагаа нь ихэвчлэн тэргүүлэх байгууллагуудын нэг болох Цагдаагийн газраас хийгддэг бөгөөд (хэдийгээр бүгдэд нь биш боловч) нисэх буудлын бүсийн гадна ч үйл ажиллагаа явуулдаг. ОБЖ-д онцгой байдлын нөхцөл бүр дээр арга хэмжээ авахад тэргүүлэн гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагуудыг тодорхойлсон байна.

Хариу үйлдэл үзүүлэх зохицуулагч талбай дээр байхгүй үед онцгой байдлын үйл ажиллагааны төв нь онцгой байдлыг зохицуулах төв нь зохицуулагчид аэродромын мэдээлэл болон нөөц эх үүсвэрүүдийн удирдлагын төв болж ослын талбарт хариу үйлдэл үзүүлэх зохицуулагчийг мэдээллээр хангана. Үнцгой байдлыг зохицуулах төв нь холбоо, захиргаа, үйлчилгээний байгууламжуудыг байгуулсан байна.

### **В.5.3 Зөрчлийн удирдлагын штаб (ЗУШ)**

#### **ИНД 139.57(б)(5)**

Олон улсын аэродром нь онцгой байдлын төрөл бүрт төлөвлөсөн удирдлагын штабтай байхыг дүрмэнд шаардсан байдаг.


ИКАО-ийн баримт бичгүүдэд ЗУШ-ийг хөдөлгөөнт байхаар зөвлөдөг. Энэ нь бас ЗУШ гэж нэрлэгдэнэ.

Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС)-ийн хандлагыг байгуулахад аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь (олон улс болон орон нутгийн үйл ажиллагаа гэхгүйгээр) ОБЖ-д төлөвлөгдсөн онцгой байдлын нөхцөл бүрийг тооцсон Зөрчлийн удирдлагын (ЗУШ)-ийг тодорхойлох хэрэгтэй.

Зөрчлийн удирдлагын баг нь мэдээллийг хүлээн авах болон тараах мөн ослын удирдлагын төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрүүдийг гаргаж ажилладаг. ЗУШ нь тээврийн хэрэгсэл буюу хөдөлгөөнт, чиргүүлэн, майхан, барилга, түр байгууламж зэрэг хэлбэрээр байж болох юм.

ЗУШ нь цаг агаарын хүчин зүйлсээс сэргийлж хаалт, халхавчтай, маш тодорхой байгуулагдсан байвал зохино. Зөрчилтэй холбоотой дуу чимээ, эргэлзээ төрүүлэхүйц зүйлсээс хол, бодит болон боломжит аюултай бүсээс хол байрласан байна.

ЗУШ- рүү орох нь хяналттай байх бөгөөд нийтийн хөдөлгөөний бүсээс хол байрлах шаардлагатай. ОБЖ-д ЗУШ нь хаана хэрхэн байршуулагдсан байх вэ гэдгийг заасан байна.



Зураг2 - Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем(ЗУЗС)-ийн схем зураг

## Хавсралт С - Эмнэлгийн анхаарах зүйлс

### С.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжүүд

ИНД 139.57(б)(6)

ОБЖ-д онцгой байдлын үед хэрэглэх шаардлагатай тоног төхөөрөмж болон эмнэлгийн төхөөрөмжүүдийг багтаасан байршлыг тодорхойлсон байна.

Эдгээр хөрөнгийн тоо хэмжээ болон эмнэлгийн тоног төхөөрөмжүүд нь тухайн аэродром дээр тогтмол нислэг үйлддэг хамгийн том зорчигч тээврийн агаарын хөлөгт

дүйсэн байхаас гадна эдгээр нь ОБ-ын үед шаардлагатай хугацаанд ослын талбай дээр ирэх боломжтой байх шаардлагатай.

**Аврах, гал унтраах, эрэн хайх аврах тоног төхөөрөмжгүй жижиг аэродромууд.** Эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгслүүд терминал дотор байх шаардлагатай.

**Аврах, гал унтраах, эрэн хайх аврах тоног төхөөрөмжтэй орон нутгийн аэродромууд.** Зориулалтын анхны тусламжийн өрөө байх шаардлагатай.

Аврах, гал унтраах ажилтан нь анхны тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан, тээврийн хэрэгсэлд болон терминал дотор шаардлагатай анхны тусламжийн хэрэгслүүдийг байршуулсан байна.

**Олон улсын аэродром.** Эмнэлгийн тусламжийн хэрэгслүүдийн төвшин нь нислэг үйлддэг агаарын хөлгийн төрөл болон хэмжээнд дүйсэн байна. Хамгийн багадаа аврах, гал унтраах тээврийн хэрэгсэлд болон терминал дотор шаардлагатай анхны тусламжийн хэрэгслүүдийг байршуулсан байна. Мөн сайтар тоноглогдсон эмнэлгийн төхөөрөмж нь чиргүүлэн болон бага оврын тээврийн хэрэгсэл байх боломжтой бөгөөд ямар ч онцгой байдлын нөхцөлд хэрэглэгдэх боломжтой байвал зохино.

Маш олон төрлийн эмнэлгийн хэрэгслүүд нь хугацаа дуусдаг учир хадгалахад яг аль нь хадгалагдах вэ гэдэг нь асуудалтай байх магадлалтай. Аэродромын онцгой байдлын Төлөвлөлтийн Хороо нь юуг хадгалах нь зохимжтой вэ гэдгийг тогтоох зорилгоор эмнэлгийн зөвлөх болон зохицуулагчийг ажиллуулах талаар анхаарах хэрэгтэй. Орон нутгийн түргэн тусламж нь шаардлагатай үед туслах боломжтой байна.

Зарим аэродромууд эмнэлгийн холбоотой эргэлтийн хөрөнгө нь аэродром дээр хугацаа хэтрэхгүй гэдгийг баталгаажуулах зорилготой орон нутгийн түргэний албатай хамтран ажилладаг. Түргэн тусламжийн хэрэгслүүдийг битүүмжилсэн саванд хадгалах, эмнэлгийн туслах хэрэгслүүдийн эргэлтэнд оруулах зэрэг арга хэмжээ авдаг. Энэхүү тогтолцоог нэвтрүүлснээр хэрэгслүүдийг зохистойгоор зохицуулах боломж бүрддэг.

Контейнерт хадгалсан эмнэлгийн хэрэгслүүд нь нисэх буудлын гадна үүссэн осол, эсхүл, саадтай замаар явах зэрэг олон төрлийн янз бүрийн замаар хялбар тээвэрлэж болдог.

Хүчилтөрөгчийн баг, бортого, хөнжил, дамнуурга зэрэг нь онцгой байдлын тээврийн хэрэгслээр олон тоогоор зөөвөрлөхөд тохиромжгүй юм.

## **С.2 Ангилах болон эмнэлгийн тусламж**

ИКАО. Док. 9137 - “ Нисэх буудлын үйлчилгээний гарын авлагын 7-р хэсэг , нисэх буудлыг онцгой байдлын төлөвлөлт, бүлэг 9,10,13 баримт бичгүүдэд нийтээр осолд нэрвэгдсэн гарз хохирлыг тооцсон Аэродромын онцгой байдлын эмнэлгийн холбоотой асуудал, түүний удирдлага зохицуулалтыг өргөн хүрээтэйгээр дурьдсан болно. Нийтээр осолд нэрвэгдсэн үед эхлээд ослын талбайгаас аюулгүй ангилах бүсэд гаргах, дараа нь эмчилгээний бүс, дараа нь тээвэрлэх бүсэд аваачаад эцэст нь эмнэлэг болон эмчилгээний төхөөрөмжүүд бүхий газруудад зөөвөрлөх зэргээр өөрчлөгддөг. Энэ аргачлалыг эмнэлэг, түргэн тусламж дагаж мөрдөх ба зөрчлийн удирдлагын зохицуулагдсан системд нийцсэн байна. Ангилах бүсэд эмнэлгийн анхны үзлэг, тусламжийн дараа хүмүүст шошго болон түүнтэй ижил зүйлүүд зүүлгэн түүгээр нь гэмтлийн зэрэглэлийг ил болгоно. Өвчтөнүүдийн шилжилт хөдөлгөөнийг мөн системийн тусламжтайгаар таних, бүртгэх ажилаагааг хэрэгжүүлдэг. Нийтийг хамарсан осол сүйрлийн үед түргэн тусламжийн ослын удирдлагын төвийн шийдвэрээр дээр дурьдсан шошгыг хэрэглэнэ. Түргэн тусламжийн үйлчилгээний төвүүд нь шошгуудыг нөөцөлсөн байна.

Зэрэглэл тогтоох, эмнэлэг эсхүл бусад эмнэлгийн төхөөрөмжүүд рүү тээвэрлэх зэрэгт гэмтэгсдийн тоо, эмчилгээний дэс дараалал тогтоох зэргээс шалтгаалаад саатал



үүсэх магадлалтай. Амь наснаас хол, алхах боломжтой гэх мэт гэмтэл бүхий хүмүүсийг эмнэлэг рүү тээвэрлэх талбайд хүлээлгэх боломжтой.

Энэ хугацаанд тэдгээр хүмүүст анхаарал тавих, бүрэн хэмжээний зохион байгуулалттай ажилд туслах зорилгоор холбогдох мэдээллийг цуглуулах зэрэг ажил хийгдэнэ.

Онцгой байдлын журмын “Нийгмийн халамжийн” тусламжийн төлөвлөгөөний дагуу ажиллах тусдаа багийг авчирсан байна.

### **С.3 Амьд үлдэгсдийг халамжлах**

Түргэн тусламжийн үйлчилгээ болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь нийтийг хамарсан ослын талбарт амьд үлдэгсдийг анхаарах асуудлыг зохицуулах төлөвлөгөөтэй байна. Гэвч аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь ослын талбайд “Нийгмийн халамжийн төлөвлөгөө” хэрэгжих үед хэрэглэх боломжтой ямар эх үүсвэр, нөөцүүд бэлэн байгаа эсэхийг анхаарна.

Олон хүн хамарсан ослын тохиолдолд явган явах боломж бүхий шархадагсдад түр хүлээх талбай байгуулсан байхыг шаардах эсхүл эмнэлгийн тусламж аваагүй хүмүүсийг холбогдох эмнэлгийн тусламжийн байгууламжууд руу илгээхийн өмнөх хүлээлгэх талбайд байна.

Иймэрхүү хүлээлгэх талбай нь нийтийн бүсээс тусгаарлагдсан, хаалт болон дулаан нөхцлийг аль болох сайтар бүрдүүлсэн, хамгаалалттай байна. Ялангуяа хаалт хамгаалалт болон дулаан орчин нь маш чухал учир зорчигчийн терминал, ангар болон бусад барилгуудын доторх талбайг ашиглахаар төлөвлөх нь зүйтэй. Хэрэв энэ нь боломжгүй бол талбайгаас тээвэрлэх болон тээврийн хэрэгсэл ашиглаж хаалт хамгаалалтыг орлуулан түр хүлээх байгууламжийг байгуулах, эсхүл, үүссэн нөхцөл байдлаас тайвшрах зэрэгт хэрэглэх нь зүйтэй.

Ослын талбар дээр болон талбараас олон тооны амьд үлдэгсдийг зөөж тээвэрлэх талаарх заалт, шаардлагыг боловсруулсан байна. Үүнд нийтийн тээвэр, ялангуяа, автобуснуудыг хамгаалах асуудал хамрагдана.

Ослоос амьд үлдсэн бүх хүмүүсийг тэдгээрийн нөхцөл байдлыг үл харгалзан эмнэлэг болон эмнэлгийн тусламжийн байгууламжууд руу тээвэрлэх ёстой.

Энэ хэдийгээр агаарын тээвэрлэгчийн үүрэг боловч гадны улсад нислэг үйлдэж байсан агаарын хөлгийн нисэх багийн эсрэг хүчирхийллийн тохиолдлын журмын дагуу нисэх багийг бусад зорчигчдоос тусгаарласан байна.

### **С.4 Амь үрэгдэгсдийн асуудлыг зохицуулах**

Аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь Цагдаа болон эмнэлгийн байгууллага ослын талбай дээр цогцос хадгалах түр зуурын байгууламж байршуулсан байх боломжийг анхаарна.

Цагдаагийн байгууллага, эсхүл, холбогдох байгууллага зөвшөөрөх хүртэл цогцоснуудыг ослын талбайгаас зөөвөрлөхгүй байна. Нөхцөл байдлаас шалтгаалаад сүйрлийн хохирогчдийг тогтоох ажиллагааны мэргэжилтнүүдийн баг мөрдлөг шалгалтын ажиллагаа явуулах, бие болон биеийн хэсгүүдийг шилжүүлэхийн тулд талбай дээрх эд мөрийн баримтуудын бичлэгийг хийх шаардлагатай байдаг.

Орон нутгийн цогцос хадгалах байгууламж нь олон тооны амь үрэгдэгсдийн цогцсыг хадгалах боломжгүй бол аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь ОБЖ-д боломжтой байрлалыг тогтоосон бана. Энэ нь орон нутгийн эмнэлгийн байгууллагуудын хамтран ажиллах талбай болно. Заасан талбайд хөргөлтийн

тоноглол бүхий агуулах, контейнер байхгүй бол орон нутгийн тээврийн байгууллага, хөргөлтийн тоног төхөөрөмжийн дэлгүүр зэрэг байгууллагуудаас авах нь зүйтэй.

## Хавсралт D - Бодит байдалд ойртуулсан онцгой байдлын дасгал сургуулилт

ИНД 139.109

### D.1 Зорилго

Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь ОБЖ-д дурьдсан бэлэн байдлыг хангах талаарх шалгалтыг явуулах зорилгоор бодит байдалд ойртуулсан онцгой байдлын дасгал сургуулилтыг тогтмол явуулах ёстой.

Энэ нь дараах үйл ажиллагаануудын аль нэгээр дасгал сургуулилтыг явуулна. Үүнд:

- (а) Онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилт нь хамгийн багадаа 2 жил тутамд 1 удаа, үүгээр илэрсэн дутагдлуудыг арилгаж сайжруулсан эсэхийг баталгаажуулах зорилгоор бүрэн хэмжээний дасгал сургуулилтын тодорхой хэсгүүдийн сургуулилт
- (б) жил тутамд хийгдэх загварчилсан цуврал шалгах сургуулилт, энэхүү цуврал шалгалтыг эхлүүлсэн эхний жилээс хойш 3 жилээс илүүгүй хугацаанд бүрэн хэрэгжүүлж дуусгана.

Илэрсэн дутагдлууд дээр үндэслэн тусгай дасгалуудын хүрээ болон хэмжээг гаргах бөгөөд шалгах тохируулах ажлыг мөн хийнэ.

Загварчилсан шалгалт нь тодорхой хэсгүүд дээр төвлөрч болох боловч дараах хязгаарын хүрээнд байна. Үүнд:

- Мэдээлэх + онцгой байдлын холбоо + түгшүүрийн дохио өгөх + уулзах цэг (УЦ) + бэлэн байдал
- Нисэх буудлын галын алба + онцгой байдлын галын алба + тактикийн дасгал сургуулилт + ослын талбайн эд мөрийн баримтыг хамгаалах + үйл ажиллагааны аюулгүй байдал (ослын талбай дээр)
- Зөөвөрлөх дасгалууд + гэмтэгсдийг зохицуулах + ангилах + эмнэлгийн тусламж + түргэн тусламж
- Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС), удирдлага ба хяналт + удирдлагын цэг + нисэх буудлын онцгой байдлыг зохицуулах төв
- Тээвэрлэлт / тоног төхөөрөмжүүд
- Ослын дуудлага хүлээн авагч + найз болон хамаатан саданг байрлуулах + агаарын хөлгийн нисэх багийг байрлуулах + хэвлэл мэдээлэл
- Хэвийн ажиллагааг үргэлжлүүлэх + үйл ажиллагааны аюулгүй байдал
- Агаарын хөлгийг сэргээх + хэвийн үйл ажиллагаанд орох + мөрдлөгө шалгалт + ослын дараах тайлан мэдээлэл

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ширээний сургалт, онцгой байдлын уулзалт, хурал,эсвэл, бусад цагт нь багуудын хэлэлцүүлэг гэх мэтийг багтаасан нэмэлт дасгал сургуулилтанд анхаарал хандуулах. Жишээ нь:

- 2003 оны SARS, 2014 оны Эбола гэх мэт олон улсад тархах магадлалтай халдварт өвчин
- Зорчигч үйлчилгээний шинэ барилга гэх мэт аэродром дээрх томоохон өөрчлөлтүүд
- Галын албаны болон түргэн тусламжийн авах арга хэмжээнүүдийг ангилах байгууллагуудын тусгай дасгалууд
- Байгууллагуудын бага хэмжээний сургуулилтууд ялангуяа сайн дурын болон ээлжийн ажилтануудтай бол хийх. Энэхүү ажиллагаа нь ОБЖ-д заагдсан хүмүүсийг аль болох олноор нь сургаж, дадлагажуулах боломж олгодог.

## **D.2 Бодит байдалд ойртуулсан онцгой байдлын дасгал сургуулилт**

Аэродромын онцгой байдлын сургалтын зорилго нь дараах нийцлүүдийг шалгана. Үүнд:

- Оролцогч бүх ажилтнуудын үүрэг, хариуцлага
- Онцгой байдлын журам болон үйл ажиллагаа
- Онцгой байдлын тоног төхөөрөмж болон холбооны хэрэгсэл

### **D.2.1 Онцгой байдлын дасгал сургуулилтын бэлтгэл**

Онцгой байдлын албанаас тогтмол зохион байгуулдаг дасгал сургуулилтын талаарх мэдлэг, ур чадвар дээр үндэслэн онцгой байдлын дасгал сургуулилтын бэлтгэх.

Онцгой байдлын дасгал сургуулилтын явц, хэрхэн дуусах зэргийг хариуцсан ерөнхий удирдагчийг томилох хэрэгтэй. Томхон хэмжээний дасгал сургуулилтанд өөрсдийн холбооны системийн шаардлага, удирдлагын сүлжээ бүхий тусгай баг ажиллах тохиолдол байдаг. Энэхүү баг нь ихэвчлэн гадны шүүгч болон дасгал сургуулилтын ерөнхий явцыг хянахаар өөр өөр байршлуудад байрласан аюулгүй ажиллагааны мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

### **D.2.2 Онцгой байдлын дасгал сургуулилтын хүрээ**

Дасгал сургуулилтын өмнө, аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь ОБЖ-ын шалгах шаардлагатай хэсэг, бүрдэл болон хэмжигдэх боломжтой зүйлсийг тогтоох шаардлагатай. Энэ нь дасгал сургуулилтын хамгийн зөв хувилбарыг боловсруулахад тусална. Хороо нь дасгал сургуулилтын үед судлах, боловсруулах бүрдлүүдэд хязгаарлалт хийх бөгөөд судалгааны орчныг сайтар бүрдүүлэх болон хамгийн хэрэгтэй зүйлсийг олох боломжийг анхаарна. Олон төрлийн хэт их хэмжээний дасгал сургуулилт нь оролцогчдийг ядраах, эргэлзээнд оруулах магадлалтай.

Тодорхой ажиллагаа болон байгууллагуудад зориулсан хэсэгчилсэн сургалтуудыг явуулах аргыг хэрэглэж болно. Энэ нь ширээний дасгал, авах арга хэмжээнүүдийг шалгах, биечлэн гүйцэтгэх дадлага гэх мэт байж болно.

Ширээний дасгалаар өрөөнд нисэх буудлын байршлын зураг болон өгөгдсөн дарааллын дагуу оролцогчдын авах арга хэмжээг тусгайлан бэлтгэсэн самбар дээр хэлэлцэх зэргийн аль ч аргыг хэрэглэн явуулах боломжтой болно. Энэ нь онцгой байдлын үед ажиллах албадуудын ердийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр мөн ямар нэгэн зардалгүйгээр онцгой байдлын нөөц, эх үүсвэрүүдийн боломж, хүчин чадал, хамтын ажиллагаа зэргийг шалгах үед хэрэглэгддэг.

Ширээний дасгалын дараагийн түвшин нь дасгалуудыг нэгбүрчлэн нягтлах ажиллагаа юм. Энэхүү дасгал нь талбай дээр хийгддэг бөгөөд хугацаа алдан удаашрах байдлыг засах, хэвшүүлэх, дасгалжилтын ямар ч үеийн үйл явдлын үр дүнг зогсоох боломжийг бүрдүүлэх, оролцогч байгууллагууд болон ажилтнуудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой.

Бүрэн хэмжээний дасгал сургуулилт талбай дээр явагдах бөгөөд өгөгдсөн онцгой байдлын зохиомжийн дагуу хариу арга хэмжээг бүрэн авах дасгал хийгдэнэ. Дасгалжуулалтын өгөгдсөн хэмжээний дагуу зарим нисэх буудал нь онцгой байдлын үе болон Сэргээх үе гэсэн 2 үе шаттайгаар буюу 2 тодорхой үе шаттайгаар дараалсан 2 өдрийн турш бүрэн хэмжээний дадлагажуулалтыг хийдэг. Энэ нь ОБЖ-ын чухал хяналт, үнэлгээг хийхэд тусладаг.

### **D.2.3 ОБ-ын дасгал сургуулилтыг төлөвлөх, хугацааг тогтоох**

Олон төрлийн онцгой байдлын үе шатны дадлагын хөтөлбөр болон хугацааг тооцоход анхаарах шаардлагатай. Онцгой байдлын зохиомжийн дагуу шөнийн цагт онцгой байдалд хариу арга хэмжээ авах нь өдрийн гэрэлтэй цагт авахаас нэлээд хэцүү төвөгтэй зэргийг тооцож сургуулилтын хөтөлбөр болон хугацааг төлөвлөх хэрэгтэй. Энэ нь хүмүүсийн тоо цөөрсөн үйл ажиллагааны оргил ачааллын бус цаг учир ажилтнуудын нөөцийн түвшинг төвлөрүүлэх шаардлага гарна. Дасгал сургуулилтыг агаарын хөлгийн нислэгийн цагийг харж өглөө эрт, орой, шөнө гэх мэт аль болох цонхтой цагт хийх хэрэгтэй. Эдгээр цагуудад осол сүйрэл тохиолдох илүү магадлалтай учир хийх дасгалын үр дүн нь бодит байдалд илүү ойрхон болно. Энэ нь онцгой байдлын албадуудын хамгийн бага ажилнуудтай үе, замын хөдөлгөөний ачаалалтай үе, ээлжийн ажилнуудын ээлж солилцох үеүдэд үүссэн тээвэрлэлтийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд илүү амар болгодог.

### **D.2.4 Оролцогсдод зохицуулалт хийж үр дүнг нэмэгдүүлэх**

Дараагийн анхаарах асуудал нь дасгалын үед бүх байгууллагуудын авах хамгийн зохистой арга хэмжээ баталгаажуулах юм. Онцгой байдал нь олон цагийн турш болон хэдэн өдөр ч үргэлжлэх боломжтой. Хүмүүс олон цагийн турш зохих түвшинд тасралтгүй ажиллах боломжгүй тул ажилтнуудыг шаардлагатай үед нь амрах нь зүйтэй бөгөөд орлох ажилтнууд нь ослыг үргэлжлүүлэн арилгахад голлох үүрэг бүхий байршлуудад ажиллахаар төлөвлөгдсөн байна. Онцгой байдлын дасгал сургуулилтанд оролцож буй байгууллагууд нь шаардлага гарвал уртасгасан цагаар ажиллах боломжтой гэдгээ мөн үзүүлэх шаардлагатай.

### **D.2.5 Бусад анхаарах зүйлс**

Зорилтоо тодорхойлох болон ОБЖ-ыг нягтлах бодит зохиомжийг боловсруулах үед Аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь дараах асуудлуудыг анхаарна. Үүнд:

- Аэродромын өөрийн үйл ажиллагаа үргэлжлүүлэх чадвар
- Сайн дурынхан болон ажилтнуудаас бүрдсэн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны оролцогчид

- Хамтран ажиллах байгууллага, холбоодууд, ялангуяа, урьдчилан ажилладаг байгууллагууд
- Даатгалын хамрах хүрээ
- Зохиомжинд агаарын тээвэрлэгч болон зорчигчдын талаар зохиомол нэрийг ашиглах
- Ажиглалтын байршлуудыг бэлтгэх, сургуулилтын дараа ажиглагчдын шүүмж бичих хуудсыг бэлтгэх

Сургуулилтын үед үүсч магадгүй онцгой байдлын бодит нөхцөлд авах арга хэмжээг гаргах г.м.

### **D.3 Дасгал сургуулилтын дараах тайлан**

*ИНД 139.109(3)*

Онцгой байдлын дасгал сургуулилтын дараа оролцогч байгууллагууд болон зорчигч, угтагсад, үдэгсэд болон жүжиглэсэн сайн дурынханы сэтгэгдлийг сонсох үүднээс дасгал сургуулилтын дараах үр дүнгийн тайланг хийнэ. Дасгал сургуулилтын үед хэрхэн аврагдсан болон зохион байгуулалтын талаар сайн дурынхны сэтгэгдлийг сонсох нь үнэтэй зөвөлгөө болдог.

Дасгал сургуулилтын үед аль хэсэг нь сайтар хэрэгжсэн, аль хэсэг нь сайжруулах шаардлагатай болон зорилгодоо хүрсэн эсэх талаар томилогдсон ажиглагчдаас шүүмжийн хуудсын дагуу санал хүсэлтийг нь авах шаардлагатай.

Бүх байгууллагууд нь өөрсдийн ажилтнуудын ажлын үр дүнгийн тайланг гаргаж туслах, аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороонд өгөх тайланг бэлдэнэ. Аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо тайлангуудыг хүлээн авсаны дараа тайланг дүгнэх, нягтлах, хэлэлцэх болон ОБЖ-д өөрчлөлт оруулах зөвлөмж гаргах талаар бүрэн хэмжээний үр дүнгийн тайлан хурлыг зохион байгуулна.

## **Хавсралт E - Бусад анхаарах асуудлууд**

### **E.1 Угтагсад болон гашуудагчдыг зохицуулах**

#### **E.1.1 Угтагсад болон гашуудагчид**

Ирж буй болон явах нислэгийн зорчигчидтэй уулзахыг хүссэн хамаатан садан, найз нөхөд, ажлын хамтрагчид зэрэг хүмүүстэй ажиллах нь агаарын хөлгийн ослын үед авах арга хэмжээний нэг юм.

Ерөнхийдөө эдгээр хүмүүсийг “угтагсад болон гашуудагчид” гэж тодорхойлдог. Хэдийгээр өмнө энэ талаар А 6.2-д дурьдсан боловч онцгой байдлын үед угтагсад болон гашуудагчидтай ажиллах, зохицуулах нь чухал бөгөөд маш анхааралтайгаар төлөвлөгдсөн байна. Угтагсад болон гашуудагчид нь ослын нөлөөгөөр сэтгэл санааны хямралд орсон байх магадлалтай тул анхааралтай зохицуулна. Мөн агаарын хөлгийн осолд өртсөн зорчигчийн талаар чухал тодорхойлолт, мэдээллийг өгөх боломжтой юм. Иймэрхүү мэдээллүүд нь шууд асуулт болон маягт бөглөх аргаар ихэвчлэн олддог.

#### **E.1.2 Аюулгүй байдал болон зориулалтын талбай**

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон агаарын тээвэрлэгч нь терминалын дотор аль нэг хэсэгт нь угтагсад болон гашуудагсдаас асуулга, уулзалт хийх боломжтой

тусгайлсан аюулгүй өрөөг бэлтгэх үүрэгтэй (уулзалтын өрөө, хурлын заал, хүндэт зочны танхим зэрэг).

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч дээрх байршлыг бэлтгэх боломжтой үед, эсхүл, угтагсад болон гашуудагчдыг олон нийтээс тусгаарлах үүргийг аль байгууллага нь хариуцах вэ гэдгийг ОБЖ-д заасан байна. Энэ байгууллага нь угтагсад болон гашуудагчдыг Цагдаагийн газар, хохирогчдыг хамгаалах төв, Аврах анги, Улаан загалмайн нийгэмлэг, мэргэжилтнүүд зэрэгтэй хамтран ажиллах талаар зохицуулалтыг хийнэ.

Дээрх хүмүүст шаардлагатай бол холбооны хэрэгсэл, зууш, ундаа зэргээр хангахаас гадна эмнэлгийн туслалцаа үзүүлэх зэрэг анхаарал тавих шаардлагатай.

Тусгаарлах өрөө нь өмгөөлөгч болон зөвлөгөө өгөх хүмүүстэй уулзах, хувийн ярилцлага хийх тусдаа өрөөнүүдэд шууд нэвтрэх боломжтой байна. Энэ нь олон нийт болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын сонирхлоос хамгаалагдсан болон ослын талбай шууд харагдах боломжийг хаасан байна.

### **E.1.3 Мэдээлэлд нэвтрэх**

Энэ хүмүүсийг цаг тутамд бодит мэдээллээр хангах нь маш чухал юм. Угтагсад болон гашуудагчид аливаа мэдээллийг олон нийт, хэвлэл мэдээлэл, бусад холбооны хэрэгслүүдээс түрүүлж авах шаардлагатай. Телевизийн дэлгэцээр гарах мэдээллийг нисэх буудал болон нисэх буудлын түрээслэгч нар дотооддоо зөвшилцөж мэдээлэгдэхээс өмнө зохицуулалт хийсэн байх ёстой ба энэ нь тэдний хариуцлагын асуудал бөгөөд нөхцөл байдал өөрчлөгдөх бүрт шүүмжлэгдэх болно.

Гэсэн ч угтагсад болон гашуудагсад нь хувийн гар утас болон компьютерээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нэвтрэх боломжтой гэдгийг анхаарах хэрэгтэй.

### **E.1.4 Жижиг үйл ажиллагаа эрхлэгчид**

Аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хороо нь онцгой байдлын үйл ажиллагааг явуулах боломжтой байнгын болон цөөн тооны, ямар нэгэн ажилтнууд бүхий жижиг агаарын тээвэрлэгчдэд анхаарал хандуулсан байна. Ялангуяа хэвлэл мэдээллийнхэн, хамаатан саднууд нь нисэх буудал дээр ирж эхэлсэн үед аэродромын эрхлэгч, цагдаа, бусад томилогдсан төлөөллүүд нь агаарын тээвэрлэгчийг төлөөлж үйл ажиллагааг явуулах шаардлага гардаг.

## **E.2 Терминалын зохион байгуулалт**

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ОБЖ-ын нэг хэсгийн дагуу терминалын үйл ажиллагааг зохион байгуулах асуудлыг анхаарна. Үүнд аэродром дээр болон түүний орчимд тохиолдсон осол, өөр аэродромд, эсхүл, алслагдсан байршилд гарсан осол зэрэг нь терминалын үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай бол холбогдох зохицуулалтыг агуулсан байна.

Нислэгийн мэдээллийн дэлгэцэн дээр гарч буй мэдээлэл, эсхүл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өгч буй мэдээлэлийг анхааралтай тэмдэглэнэ. Дараах зүйлсийг анхаарах:

- Нислэгийн бүс болон агаарын тээвэрлэгчийн оффист нэвтрэхийг хэрхэн хязгаарлах. Эдгээр нь онцгой байдлын үед хүмүүсийн хамгийн ихээр нэвтрэхийг хүсдэг байршлууд юм.
- Шаардлагатай үед авах нийтийн бүсийн хяналтын арга хэмжээнүүд, хувийн хамгаалалтын алба, нисэх буудлын хамгаалалтын алба, эсхүл, тодорхой бүсийг хамгаалалтанд авах нэмэлт нөөц.

- Лавлах төвүүдэд ямар мэдээллүүд боломжтой эсэх болон хэрхэн холбогдох зэрэг
- Хүнсний дэлгүүр зэрэг нь нээлттэй байх, нэмэлт катерингийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо тогтоосон байх.
- Аэродром хаалттай үед буюу үйлчилгээний бус цагаар осол гарсан тохиолдолд онцгой байдлын төлөвлөлт болон терминалын зохицуулалт зэрэгт нөлөө үзүүлнэ гэдгийг тооцох.
- Ослын нөхцөл дуустал ойр байрлахыг хүссэн хамаатан садан, найз нөхөд, дэмжлэг үзүүлэх байгууллагууд, нисэх буудлын ажилтнууд, хэвлэл мэдээлэл зэргийг байрлуулах томоохон зочид буудал, амралт, цэнгээний газар зэрэг нөөц байршлууд гэх мэт.

### **Е.3 Ослын талбай - нотлох баримтуудыг хамгаалах**

ИНД - 12

#### **Е.3.1 Нотлох баримтыг хамгаалах**

Агаарын хөлгийн ослын дараа холбогдох агаарын хөлгийн үйлдэгдэл, бүрдэлүүд, бусад биет зүйлүүдийг зайлуулахаас өмнө ослыг мөрдөн шалгах ажиллагаа явагдана. Мөрдлөгийн байгууллагад ослын талбар дээрх нотлох баримтуудыг хамгаалалтанд авах нь чухал бөгөөд онцгой байдлын арга хэмжээ авах үед ослын талбай аль болох бага талхлагдсан байна.

Иргэний нисэхийн дүрэм 12, Дэд бүлэг Ц - Агаарын хөлөг болон түүний эд ангиуд, бичлэгүүдийг хамгаалах - агаарын хөлгийн осол тохиолдсон талбайн нотлох баримтуудыг хамгаалах шаардлагуудыг дурьдсан байдаг.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь дүрмийн энэхүү шаардлагуудыг ойлгосон, хэрэгжүүлэх үйл ажилаагааны процедуртай байх нь чухал юм.

Нэмэлт гарын авлагууд нь ИНЕГ-ын номын санд болон <http://mcaa.gov.mn> цахим хуудсанд байрлана.

#### **Е.3.2 Мөрдөх ажиллагаа болон сүйрлийн үлдэгдлийг цэвэрлэх**

Дараах 3 байгууллага нь агаарын хөлгийн ослын үед шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй болно. Үүнд:

- Зам Тээврийн Яам
- Иргэний Нисэхийн Ерөнхий Газар
- Цагдаагийн Газар

Дээрх шинжлэн шалгах ажиллагаанд оролцсон аль ч байгууллага сүйрлийн үлдэгдлийг цэвэрлэх, зайлуулах боломжтой.

Агаарын тээвэрлэгч нь ОБЖ-д заасны дагуу осолдсон агаарын хөлгийг зайлуулах үүрэгтэй бөгөөд ,эсхүл, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй зөвшилцөн ажиллана.

#### **Е.3.3 Сүйрэл**

Цагдаагийн газар нь амь үрэгдэгсдийн шинжилгээний ажлыг хариуцна. Цогцос болон биеийн хэсгүүдийг осолд нэрвэгдсэн хүмүүсийг таних ажиллагаанд хэрэглэх болон цагдаагийн газрын зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөх ёсгүй.

### **Е.3.4 Хөнгөн агаарын хөлгийн осол**

Ямар нэгэн амь эрсдэл болон ноцтой гэмтэл бэртэлгүй хөнгөн агаарын хөлгийн ослын хувьд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон агаарын тээврлэгч нь ослын үлдэгдлийг зайлуулах зөвшөөрлийг ИНЕГ-аас мөн албан ёсоор авна.

Хэрэв аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-ын байцаагч нарыг ирэхээс өмнө үзлэг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан бол ослын үлдэгдэл зайлуулах болон хэвийн үйл ажиллагааг түргэсгэж болно.

Үүнийг хийхэд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-ын өмнөөс үзлэгийн ажлыг эхлүүлэх, гүйцэтгэхдээ ИНЕГ-аас гаргасан зөвшөөрөл болон, зааврыг бүрэн судалсан байна.

Ослын болон нөхцөл байдлын хүндрэлээс шалтгаалан ИНЕГ урьдчилан зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд зарим зөвшөөрлүүд нь хэрэглэх боломжгүй байдаг. Үүнд:

- Ослын үед анхан шатны үзлэг хийх сургалтанд суусан ажилтнуудтай бол
- Нотлох баримтуудыг цуглуулах, фото зураг авах, эд мөрийн баримтын байршлыг тэмдэглэх, талбарын ноорог зураг, тодорхойлох тэмдэглэлүүд болон ИНЕГ-аас шаарддаг бусад ажиллагаанууд гэх мэт.

### **Е.4 Хэвийн үйл ажиллагаанд эргэж орох - сэргээх үе шат**

ОБЖ-ын нэг сэдэв бол Аэродромын онцгой байдлын нөхцлөөс байдлаас шалтгаалсан агаарын хөлгийн үйл ажиллагаанд саад учруулах зүйлсийг багасгах юм. Аэродром дээр тохиолдсон агаарын хөлгийн ослын үед аэродромыг түр хугацаагаар хаах шаардлага үүсдэг.

ОБЖ нь аэродромыг аюулгүй статустай, үр ашигтай, зохион байгуулалттай, бүрэн хэмжээний үйл ажиллагаатай ашиглалтанд эргэж оруулах ажлуудыг оруулсан байна.

Онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаалаад агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг тодорхой үе шат, хязгаарлалттайгаар сэргээж болох бөгөөд энэ нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэвийн ажиллагаанд орох хүртэл үргэлжилнэ.

Агаарын хөлөг нислэгийн хязгаарлалтад орох гэдэг нь онцгой байдал, эсхүл, сэргээх ажиллагаанд өртөөгүй аэродромын хөдөлгөөний бүсийг ашиглан нислэгийн үйлдвэрлэл эхлүүлэх ажлыг хэлнэ.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромыг хэвийн үйл ажиллагаанд эргэж оруулахдаа дараах асуудлуудыг анхаарна. Үүнд:

- Барилга байгууламжууд нь ажиллагаатай эсэхийг тогтоох ,эвдрэл гэмтлийн үнэлгээ хийх.
- Хөдөлгөөний бүсэд гадны хаягдал биетүүд бий эсэх үзлэгт онцгой анхаарах. Хөөрч буух хучилтгүй /шороон/ зурвас болон явгалах замууд нь бусад агаарын хөлөгт гэмтэл учруулж болохуйц гадаргын хонхор, гүдгэр байгаа эсэхийг нягтлах. Аэродромын хөөрч буух зурвас болон явгалах замуудын орчмын хөрсний гадаргууд засвар, шинэчлэл хийх шаардлагатай бол бусад агаарын хөлөгт анхааруулах үүднээс тухайн бүсэд анхааруулах тэмдэгт байрлуулж нислэгийн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой бөгөөд дараа нь засварлах.
- Саад тотгор, эвдрэл гэмтлээс шалтгаалаад аюултай бүсүүдийг хааж тэмдэгжүүлнэ. Үүнд сэргээх ажил хийгдэж буй бүс болон ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн явах зам маршрутын хэсгүүд мөн орсон байна.
- Сэргээх ажиллагаанд ашиглаж буй тоног төхөөрөмж болон хөдлөх чадваргүй болсон агаарын хөлөг нь саадыг хязгаарлах хавтгайг зөрчиж буй эсэх, мөн



холбоо навигацын тоног төхөөрөмжүүд болон ойртолт үйлдэж буй агаарын хөлгийн ил хараанд нөлөөлөх эсэхийг анхаарах. Хэрэв саадын хязгаарлах хавтгайд нэвтэрсэн бол хөөрч буух зурвасны ашигтай уртын багасгасан хэмжээг тооцож нислэгт ашиглах бөгөөд шаардлагатай аюулгүйн зайнуудыг хангасан байна.

- Нислэгийн үйл ажиллагааг сэргээхэд гал унтраах чадвар, боломжийг дахин үнэлэх хэрэв шаардлагатай бол НОТАМ мэдээ зарлах.
- Онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаалж аэродромыг хаасан ямар нэгэн НОТАМ мэдээг цуцлах. Нислэгийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон бүсүүдийг хаасан тухай, эсхүл, хөөрч буух зурвасны ашигтай уртын багасгасан хэмжээг өөрчилсөн болон шинээр ашиглах тухай, онцгой байдлын нөхцлөөс болоод агаарын хөлгийн хөдөлгөөн хязгаарлагдсан тухай зэрэг НОТАМ-уудыг шинээр зарлана.

## **E.5 Бодит онцгой байдлын дараах тайлан**

### *ИНД 139.109(3)*

ОБЖ-ыг бүхэлд нь болон хэсэгчлэн идэвхижүүлэх онцгой байдлын нөхцлийн дараах тайланг заавал гаргана. Онцгой байдлын нөхцөл дуусмагц томилогдсон эрх бүхий ажилтан нөхцөл байдлын талаар эргэж тайлан тавих нь зохимжтой байдаг. Энэ нь үүссэн онцгой байдлын нөхцөл хүндэрсэн байдлаас мөн хамаардаг бөгөөд аэродромын онцгой байдлын албадын нэгдсэн үр дүнгийн тайлангийн хурлыг зохион байгуулах нь холбогдох албад тус тусдаа хийснээс илүү үр дүнтэй байдаг.

Үр дүнгийн тайлан хурлын хуваарийг хойшлуулж гаргах нь аэродромын онцгой байдлын төлөвлөлтийн хорооны бүх гишүүдэд оролцох боломж олгодог.

## **E.6 ОБЖ-ын тогтмол хяналт**

### *ИНД 139.101*

ИНД нь аэродромын гэрчилгээ эзэмшигчийг өөрийн ОБЖ-ийг /тайлбар бичгийн нэг бүрдэл/ тогтмол шинэчилж байх, онцгой байдлын бодит нөхцөл болон дасгал сургуулилтаар нягталж, баталгаажуулж байхыг шаарддаг бөгөөд, бүх ажилтнуудын холбогдох утасны дугаар болон түгээгдсэн хуудсуудыг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэж байх ёстой.

Бусад аэродромуудын онцгой байдлын үед авах үр дүнтэй арга хэмжээ, шинэлэг санаачилгуудыг судлах зэрэг нь ОБЖ-ыг сайжруулах дараагийн боломж болдог. Бусад аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо тогтоох, тэдгээрийн онцгой байдлын сургуулилт болон үр дүнгийн тайлангийн хуралд оролцох боломжыг ашиглах нь маш үр дүнтэй байдаг.

Онцгой байдлын удирдлага, эсхүл, агаарын хөлгийн осол нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдэд бусдаас туршлага судлах боломж олгохоос гадна өөрсдийн ОБЖ-д байгаа ижил төстэй, давуу болон сул талуудыг олж харах боломжийг бүрдүүлдэг.

## **Хавсралт F - Холбогдох мэдээллүүд**

### **F.1 Бичиг баримтууд**

ИКАО

Хавсралт 14 - Боть 1 -Аэродромын төлөвлөлт болон үйл ажиллагаа

Док 9137 -Нисэх буудлын үйлчилгээний заавар, Бүлэг 7 -Аэродромын онцгой байдлын төлөвлөлт  
Док 9683 -Хүний хүчин зүйлсийн сургалтын заавар

ИНЕГ

Иргэний нисэхий дүрэм 12, Дэд бүлэг С - Агаарын хөлөг түүний эд ангиуд болон бичлэгүүдийг хамгаалах, ИНД 139 - Аэродромууд - Гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагааба ашиглалт